

БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ

.....

БАТЛАВ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ

Ж.ГАНБАТ

.....



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ТАВАН ТОЛГОЙН НҮҮРСНИЙ
ОРДЫН ЦАНХИ, БОРТЭЭГИЙН УУРХАЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:
MV- 016881, MV- 016882, MV- 011943, MV- 011956, MV- 016883

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5435528

ХЯНАСАН:

БОАЖА-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

БОЛОВСРУУЛСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ХАББОГ-ЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

Гарчиг

1	Төслийн танилцуулга	1
1.1	Оршил	1
1.2	Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал.....	1
1.3	Тавантолгой ордын геологийн тогтоц.....	2
1.4	Уулын ажлын ерөнхий мэдээлэл.....	2
1.5	2024 оны уулын ажлын төлөвлөлт	3
1.6	Туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл	3
2	Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	3
2.1	Уур амьсгал	3
2.2	Геоморфологи	4
2.3	Ус зүй ба гидрогеологийн нөхцөл	4
2.4	Хөрс.....	4
2.5	Ургамлан бүрхэвч.....	4
2.6	Нийгэм, эдийн засаг	5
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	6
3.1	Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц.....	6
3.2	Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ	7
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	10
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
5.1	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	17
5.1.1	Тоос бууруулах технологийн ажил	17
5.1.2	Уурхайн ашиглалтын замыг сайжруулах.....	17
5.1.3	Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиньг тогтмол ажиллуулах.....	17
5.1.4	Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих	17
5.1.5	Туслах шороон замуудын нөхцөлийг сайжруулах чиглэлийн ажил	17
5.1.6	Нүүрс тээвэрлэлтийн машинуудын хяналт	17
5.1.7	Нүүрс ачилтын талбайд усалгаа хийх	18
5.1.8	Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	18
5.1.9	Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих.....	18
5.2	Усан орчинд учруулах нөлөөллийг багасгах төлөвлөгөө	18
5.2.1	Газар доорх усны бохирдлоос хамгаалах	18
5.2.2	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх	18
5.2.3	Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх	18
5.2.4	Замын тоосжилт бууруулахад ашиглах гадаргын болон гүний усны харьцааг 0.32-аас бага түвшинд байлгах.....	18
5.2.5	Бохир усыг зөвшөөрөлтэй газар нийлүүлэх, саарал усыг дахин ашиглах	19
5.2.6	Уурхайн газар доорхи усны нөөц, чанарт байнгын хяналт тавих	19
5.2.7	Булгийн эхийг хамгаалах	19

5.3	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
5.3.1	Нүүрс устөрөгчийн хяналтгүйгээс хөрс бохирдох	19
5.3.2	Технологийн горимын мөрдөлтийг хангуулах ажиллагаа.....	19
5.3.3	Хөрсний үржил шим алдагдах	20
5.3.4	Тусгай зөвшөөрлийн талбайд зөвшөөрөлгүй ААН үйл ажиллагаа явуулж хөрсий элэгдэл эвдрэл, бохирдол үүсгэх.....	20
5.3.5	Ил уурхай, хаягдал чулуулгийн гадаад овоолгын шимт хөрс олборлолтод өртөх	20
5.4	Газрын хэвлийд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө.....	20
5.4.1	Журмын хэрэгжилтийг хангах	20
5.4.2	Олборлолтын улмаас газрын хэвлий эвдрэх, нөлөөлөлд өртөж доройтох	20
5.5	Ургамлан нөмрөгт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө ..	20
5.5.1	Нэн ховор, ховор ургамлыг шилжүүлж суулгах.....	20
5.5.2	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах	21
5.6	Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	21
5.6.1	Биотехникийн арга хэмжээ.....	21
5.6.2	Шувууны өртөлтийг багасгах арга хэмжээ	21
5.6.3	Хулгайн ангаас сэргийлэх сургалт зохион байгуулах	21
5.6.4	Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулахад орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах.....	21
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	22
6.1	Техникийн нөхөн сэргээлт.....	23
6.1.1	Газрын элэгдэл эвдрэлийн судалгаа гаргах, техникийн нөхөн сэргээлт хийх.....	23
6.2	Биологийн нөхөн сэргээлт.....	23
6.2.1	Үрийн нөөц бүрдүүлэх ажил.....	23
6.2.2	Модлог ургамлын мөчир бэлтгэх.....	23
6.2.3	Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бордоог нөхөн сэргээлтэд ашиглах	23
6.3	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн.....	Error! Bookmark not defined.
6.3.1	Өмнөговь аймгаас хуваарилсан 3.5 сая модны төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Error! Bookmark not defined.
6.3.2	Төлөвлөсөн талбайд Заг мод тарих	Error! Bookmark not defined.
6.3.3	Модлог ургамлын тарьц үржүүлэх	Error! Bookmark not defined.
7	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ	23
7.1	Урт хугацааны төлөвлөгөө гаргах.....	24
7.2	Өмнө жил хийгдсэн ажилаа малчдад тайлагнах.....	24
7.3	Хулгайн антай тэмцэх	24
7.4	Бэлчээр усжуулах.....	Error! Bookmark not defined.
7.5	Ургамлын нөмрөгийг сайжруулах	24
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	24
9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
10	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	26
11	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	28
11.1	Аюултай хог хаягдал	30
11.1.1	Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу байгуулах	30

11.1.2	Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх	30
11.1.3	Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын талбайн стандартыг хангуулахад хяналт тавих.....	30
11.2	Ахуйн хог хаягдал.....	30
11.2.1	Уурхайн хог хаягдлын түр цэг тогтоолгож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	30
11.2.2	Хоол хүнсний хаягдал зайлуулж буй цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх.....	30
11.2.3	Дахивар хаягдлыг ангилан ялгаж, хүлээн авах байгууллагад нийлүүлэх	30
11.2.4	Хог хаягдлын урсгалыг хянах, бүртгэлжүүлэх	31
11.2.5	Шаардлагатай байршлуудад хог хаягдлын ангилан ялгах савыг шинээр байршуулах, шинэчлэх	31
11.2.6	Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж тухай бүрт нь сумын төвлөрсөн хогийн цэгт буулган төлбөрийг төлж барагдуулах	31
11.2.7	Хог хаягдлын ландфиллын талбай байгуулах газрыг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газрын зөвшөөрлийг авах, зураг төслийг боловсруулж эхлэх.....	31
11.2.8	Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу зогсоолын талбай байгуулах	31
11.2.9	Нүүрс тээврийн замын хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	31
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	32
12.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ	32
12.1.1	Гадаад орчны аэрозолын хэмжилт, тархалтын судалгаа	34
12.1.2	Цаг агаарын үзүүлэлтийн хэмжилт, судалгаа.....	34
12.1.3	Хийн төлөвт бохирдуулагч болон хүлэмжийн хийн судалгаа	34
12.1.4	Дуу чимээний хяналт, тархалтын судалгаа	35
12.1.5	Мониторингийн хөндлөнгийн хэмжилт хийлгэх, дүгнэлт гаргуулах	35
12.1.6	Тоосонцорын агууламжийн хүнд металлын шинжилгээ	35
12.1.7	Цацрагийн хяналт, шинжилгээ	36
12.2	Усны хяналт шинжилгээ.....	37
12.2.1	Газар доорх усны горимын судалгаа	38
12.2.2	Бага гүний уст цэгүүдийн судалгаа	38
12.2.3	Усны геохимийн үзүүлэлтийн тодорхойлолт	38
12.2.4	Усны эрүүл ахуйн үзүүлэлт, бохирдлын судалгаа	39
12.2.5	Саарал усны хяналт шинжилгээ	39
12.3	Хөрс, ургамлан бүрхэвчийн мониторинг	40
12.3.1	Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	42
12.3.2	Хөрсний чанар- нянгийн шинжилгээ	42
12.3.3	Хөрсний чанар- Хүнд металлын шинжилгээ.....	42
12.3.4	Шимт хөрсний овоолгын чанарын шинжилгээ.....	42
12.3.5	Бэлчээрийн ургамлын мониторинг.....	42
13.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	44
14	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	48
15	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.....	49
16	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР	50

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Оршил

Уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлж түүнийг арилгах, багасгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчмуудын нэг юм.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь улс орон болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулахын зэрэгцээ нээлттэй ил тод байдал, тогтвортой хөгжлийг үнэт зүйлээрээ тодорхойлсон. Тиймээс байгаль орчны хамгааллын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллаж байна.


Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани нь олон улсын нэгдсэн менежментийн тогтолцоог /ISO 14001:2015, ISO 45001:2018, ISO 9001:2015/ нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Дээрх стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгасан ба Тавантолгой орд газрын Цанхийн баруун, зүүн болон Бортээгийн уурхайд үйл ажиллагаа явуулж буй гүйцэтгэгч компаниудад нэгэн адил хэрэгжүүлнэ.

1.2 Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Таван толгойн нүүрсний орд газар нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Улаан нуурын хөндийд, Улаанбаатар хотоос өмнө зүгт 540 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумаас зүүн урд зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун өмнө зүгт 18 км Сайншанд өртөөнөөс 440 км, Монгол-Хятадын хилийн боомт Гашуун Сухайтаас 240 гаруй км, Оюу толгой зэс, алтны ордоос 150 гаруй км-ийн зайд оршино.



Зураг № 1. Тавантолгой ордын байршил.

1.3 Тавантолгой ордын геологийн тогтоц

Орд нь Өмнөд говийн нүүрсний сав газарт багтдаг Улаан нуурын нүүрст хөндийн (200 ам км) баруун хэсгийн Тавантолгой синклиналь атра (100 ам км)-нд хамаардаг.

Тавантолгой синклиналь атирааны төв хэсэг дээд пермийн нүүрс агуулагч хурдсаар дүүргэгдэж дунд-дээд девон, доод карбон, хожуу карбон-түрүү пермийн вулканоген тунамал хурдсууд ордыг эмжээрлэн тогтох гүвээ толгод илэрнэ. Хязгаарлагдмал бага талбайд кайнозойн хурдас хөгжсөн байдаг.

Тавантолгой ордын Тавантолгой формацын нүүрс агуулагч хурдаст 1-86 метр хүртэл зузаантай нүүрсний 0-XIII нэршилтэй (VIII давхраас чулууны үетэйгээр 1298-р цооногт 86.2м, 1295-р цооногт 74 метр зузаантай тэмдэглэгдсэн байдаг) давхраасууд агуулагддаг байна. Цанхийн талбайн хэмжээнд нүүрсний 0-IX хүртэлх 10 давхраас байдаг ба талбай нь баруун талаараа хайгуулын XII, зүүн талаараа XIII, хойд талаараа XI шугамаар хязгаарлагддаг ажээ. Дээд пермийн нүүрс агуулагч хурдсанд агуулагдах нүүрсний давхраасууд нь янз бүрийн чиглэлд хэд хэдэн удаагийн давтамжтайгаар салаалан зузаан нь багасч яваандаа шувтарч алга болдог байна.

Нарийвчилсан болон ашиглалтын хайгуулын явцад тогтоогдсон томоохон хагарлын ойр орчинд тасралтат эвдрэлийн шинж тэмдгийг илэрхийлсэн хэдэн нэмэлт атираажилт тогтоогдсон байдаг байна. Нарийвчилсан, урьдчилсан хайгуулын талбайд явуулсан ерөмдлөгийн материал, хайгуулын зүсэлтүүдийг боловсруулан үзэхэд ордын хэмжээнд нүүрсний үндсэн давхраасууд нь харьцангуй тогтвортой нь ажиглагдаж байсан. Нүүрсний давхрааст ихэвчлэн нүүрслэг аргиллит, алевролит, элсэн чулуу, каолинитын үеүд илэрдэг. Тавантолгой формацын давхаргазүйн зүсэлтийн доод хэсэгт багаас дунд зэргийн зузаантай давхраас (0, I, II, III, IV), дунд хэсэгт их зузаантай давхраас (VIII-IX), дээд хэсэгт бага-дунд зэргийн зузаантай давхраас (X-XIII) тус тус тохиолддог байна.

1.4 Уулын ажлын ерөнхий мэдээлэл

2010-2022.11.30-ны байдлаар Цанхийн уурхайгаас нийтдээ 602.1 сая м3 уулын цул олборлосоноос 516.3 сая м3 хөрс хуулж, 120.6 сая тонн нүүрс олборлож, 115.5 сая тонн нүүрсийг экспортонд гаргасан байна.

Цанхийн Баруун уурхайгаас 2023 оны 11-р сарын 30-ны байдлаар нийт 26.9 сая м3 уулын цулын ажил хийснээс 20.7 сая м3 хөрс хуулж, 9.5 сая тонн нүүрс олборлож, 10.9 сая тонн нүүрсийг экспортонд гаргасан байна. Цанхийн Зүүн уурхайгаас нийт 70.8 сая м3 уулын цулын ажил хийснээс 59.5 сая м3 хөрс хуулж, 15.7 сая тонн нүүрс олборлож, 15.6 сая тонн нүүрсийг экспортонд гаргасан байна.

“Эм Эм Маркет” ХХК-тай гэрээ байгуулан Цанхийн баруун, зүүн уурхайн болон Бортээгийн уурхайн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг хийлгэсэн.

1.5 2024 оны уулын ажлын төлөвлөлт

2024 онд Цанхийн зүүн уурхайгаас 85.3 сая м³ хөрс хуулж, 15.0 сая тн нүүрс олборлох буюу нийт 96.0 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Сард дунджаар 8.0 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Мөн 13.45 сая тн коксжих нүүрс, 1.55 сая тн эрчим хүчний нүүрс олборлоно.

2024 онд Цанхийн баруун уурхайгаас 60.0 сая м³ хөрс хуулж, 12.0 сая тн нүүрс олборлож нийт 68.6 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Сард дунджаар 5.7 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Мөн 8.0 сая тн коксжих нүүрс, 2.0 сая тн эрчим хүчний нүүрс олборлоно.

2024 онд Бортээгийн уурхайгаас 20.0 сая м³ хөрс хуулж, 5.0 сая тн нүүрс олборлож нийт 23.6 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Сард дунджаар 2.6 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Мөн 3.5 сая тн коксжих нүүрс, 1.5 сая тн эрчим хүчний нүүрс олборлоно.

1.6 Туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл

Хүснэгт 1. Туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл.

Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын хаяг
“Ти эн түншлэл”	Уулын цул олборлох, нүүрс ачих	ХУД, 15-р хороо, Моннис Бьюлдинг 6-р давхар
“Үндэсний оператор түншлэл”	Уулын цул олборлох, нүүрс ачих	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Чингисийн өргөн чөлөө Нью Сенчурн Плаза
“Спейшл Майнинг Сервис” ХХК	Тэсэлгээ	БЗД, 25-р хороо, Жамьян гүний гудамж 18/1 Даун Таун оффис, 6 давхар, 602 тоот
“Кэй Эй Рентал сервис” ХХК	Уурхайн нүүрс ачилт	БГД, Таван шар “Хишиг Арвин индустриал” ХХК-ийн оффис

2 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -14.8⁰С хүрдэг, үнэмлэхүй их температур нь 41.3⁰С хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 8.0⁰С.

Жилийн дундаж агаарын температур нь 0.9⁰С, хамгийн хүйтэн I сарын дундаж температур -14.6⁰С бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 23.1⁰С байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

2.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Таван толгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

2.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Талбайн хэмжээнд байнгын урсгал ус байхгүй. Бороо их орсон үед хуурай сайр жалга нь түр зуурын урсгал устай болох ба уулс хоорондын хөндий, хотгоруудад түр зуурын давсархаг нуурууд үүсдэг. Уурхайн үерийн шуудуу, хөрсний овоолго, дэвсэлт хийж байгуулсан зам зэрэг антропоген байгууламжуудад хаагдан түр зуурын тогтонги ус үүсч бий болдог ба тус усыг уурхайн тоосыг бууруулахад өргөн хэрэглэж байна. Колдышева. Р.Я. нарын зохиосон гидрогеологийн 1:500 000 зурагт Улаан нуур хэмээх тойрмыг “шорвог устай нуур” гэж тэмдэглэсэн байдаг. Уг тойромд сүүлийн олон жилийн туршид ус хуримтлагдаагүй байсаар 2018 оны зуны дараалласан их аадар борооны үр дүнд эргээсээ хальж дүүрсэн байна. Уурхайчид Улаан нуурын ус хальж карьер руу орж ирэх вий гэсэн айдас тухайн үед байсан. Гэсэн ч энэхүү их хэмжээний ус 2019 оны зуны халуунаар ууршиж алга болсон.

Таван толгойн ордын орчимд байнгын урсгал болоод тогтмол ус байхгүй учраас гадаргын ус хуурай сайрууд болон Улаан нуурт түр хугацаанд үүсч байсан, эс үүсч байсан, хуурай сайруудаар үерийн ус урсаж юмуу, ус тогтож байсан эсэх, хэрэв ус урсаж юмуу тогтож байсан бол хэдий хэмжээний урсац, тогтмол ус үүсч байсан талаар албан ёсны ямар нэгэн мэдээ сэлт байхгүй байна (2009).

Тавантолгой Цанхийн баруун болон Цанхийн зүүн уурхай тэлж Бортээгийн талбайд хөрсний овоолго байгуулж эхэлсэн цагаас Улаан нуур руу зүүн талаас цутгадаг урсгал хаагдах болсон байна. Ингэснээр 2018 оны зун улаан нуурын зүүн талд Улаан нуурын Бортээгийн отвал руу хүрдэг замын баруун талаар хангай газрын жижиг гол руугаа адил морфологитой урсгал ус үүсч улирлын турш байсан.

2.4 Хөрс

Хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

2.5 Ургамлан бүрхэвч

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ний уул уурхайн нутаг нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт, ландшафт-экологийн мужлалаар Дундад говийн муж, Даланзадгадын районд гүвээ толгод бүхий уудам хөндий, хужир марцтай хотгор, цөлөрхөг хээрийн ургамал зонхилсон газар юм. Ургамал бүрхэвч нь газрын гадаргын байдал, хөрсний бүтэц, усан хангамжаас шалтгаалан таана-баглуурт, таана-хялгана, бор бударгана, улаан бударгана зэрэг эвшил бүлгэмдэлээс бүрдэх бөгөөд алтан харгана, дэрс, загсгал, догар, хотир зэрэг

сөөг олон наст болон нэг наст өвслөг ургамлууд оролцдог байна. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна.

2.6 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2022 оны байдлаар нийт 72395 хүн бүртгэгдсэнээс Цогтцэций суманд 8926 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус тус хил залгана.

Хүснэгт 2. 2022 оны хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	72395	8926
Эрэгтэй	36542	4364
Эмэгтэй	36393	4564
Өрхийн тоо	23165	2643

Компанийн олон нийт хамтын ажиллагааны нэгжийн зүгээс орон нутагтай хамтран ажиллах гэрээний дагуу ЭТТ ХК-ийн уурхайд орон нутгаас 221 иргэдийг ажлын байраар хангаж төлөвлөгөөний дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулдаг.

Өмнөговь аймаг нь 2022 оны байдлаар 15 сумын 59 багт 2.6 сая толгой мал тоолуулж, үүнээс Цогтцэций суманд 177,97 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт 3. 2022 оны мал тоо, мян.мал

Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	2637.3	112.45	34.76	164.77	675.72	1649.63
Цогтцэций	177.97	12.51	2.75	3.99	62.34	96.39

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төсөл жилдээ 20 сая.тн нүүрс олборлон экспортлож байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 20-30 туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.

Мөн 2019 оноос Улаанбаатар хотыг утаагүй болгох ажлын хүрээнд 100 орчим хүнд даацын машинууд нүүрс тээвэрлэж, зам дагуу нутагладаг малчдын бэлчээрийг талхалж, тоосжилт үүсгэн, өдөр шөнөгүй тээвэр хийж байна. Мөн замын дагуух худаг усыг бохирдуулах, хог хаягдал үүсгэх, зогссон газраа засвар үйлчилгээ хийж тос тосолгооны материалын асгаралтыг үүсгэж нь байгаль орчинд маш их нөлөө үзүүлж байна. Тус сумаас хот хоорондын төв зам хүртэл 59.6 км шороон зам байдаг нь үүнд нөлөөлж байна. 2018 онд Монгол улсын хүний эрхийн Үндэсний комиссоос “Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”-г хийсэн байдаг бөгөөд тус арга хэмжээний олон талт хэлэлцүүлэгт Цогтцэций сумын төв (Өгөөмөр баг) болон Цагаан-Овоо багийн иргэдээс авсан судалгаагаар 80 орчим хувь нь тоосжилт, агаарын бохирдлыг бууруулах асуудлыг хамгийн ихээр тулгамдаж буй асуудал гэж үзсэн байна.

Нүүрс тээврийн жолооч нарын асуудалд Засгийн газраас анхаарч Цогтцэций суманд “Тээвэрчдийн хотхон” байгуулах ажил амжилттай хэрэгжиж байна. Ингэснээр 4 болон 6 дахь гармын ойр орчимд байсан аж ахуйн нэгж, үйлчилгээний газар, хувь иргэдийг эмх цэгцэнд оруулж зохион байгуулалт сайжирсан. Тээвэрчдийн хотхон нь нэг ээлжиндээ 500 жолооч хүлээн авах хүчин чадалтай юм. Мөн гадна талбайдаа 1000 машины зогсоолтой, эмнэлэг, шатахуун түгээх, ачилт хүлээлгийн талбайтай юм. Тус цогцолбор бүрэн үйл ажиллагаанд орсноор Цогтцэций сумын эмнэлгийн ачаалал болон эмх замбараагүй сумын төвөөр явдаг тээврийн хэрэгслийг эмх цэгцэнд оруулах юм. Мөн байгаль орчинд хаягдах асар их хог хаягдлыг төвлөрсөн менежментэд шилжүүлж байгаа юм. Гацуун сухайтын 250 км авто замаар 14000 орчим машин нүүрс тээвэрт явж байна. Тус тээврийн хэрэгсэл нь Тавантолгой

– Цагаан хад – Гашуун Сухайт чиглэлд үйл ажиллагаа явуулдаг 176 аж ахуйн нэгжид харьяалагддаг.

3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны удирлагын тогтолцооны стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болсноор компани байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлон гаргав.

3.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт 4. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт 5. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт 6. Үр дагаврын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршгийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

3.2 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлал	ҮД ¹	Э.З. ²	Хариу арга хэмжээ
1	2	3	4	5	6	7
Ажилчдын хотхон эрхлэх	Дулаан түгээх	Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Мод тарих
			4	1	II	Түлш зарцуулалтын хяналт
	Их хэмжээний хог хаягдал	Лэнд-филийн талбай нэмэг-дэнэ	5	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт
			5	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
			5	4	IV	Биоадралд ордог бүтээгдэхүүн
Барилга шинээр байгуулах	Барилгын хог гарах	Хөрсний бохирдол	4	3	III	Хог хаягдлыг ангилан ялгалт, дахин боловсруулалт
Гадаад тээвэр хийх	Техникийн хөдөлгөөн, салаа зам	Хөрсний эвдрэл	4	3	III	Тоос бууруулах арга хэмжээ
			4	3	III	Хөдөлгөөний хязгаарлалт
			4	3	III	Хөрсний өөрчлөлтийн хяналт
Засвар, угсралт эрхлэх	Ашигласан сэлбэг, хэрэгсэл хаягдана	Хөрсний бохирдол	4	4	IV	Хог хаягдлыг ангилан ялгалт, дахин боловсруулалт
			4	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
			4	4	IV	Ажлын байрны тогтмол үзлэг
	Бохирлогдсон материал хаягдах		4	3	III	Аюултай бодисын удирдлага
			4	3	III	Хөрсний бохирдлын хяналт
	Тос, шингэн материал хаягдана		4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө
			4	4	IV	Хөрсний бохирдлын хяналт
			4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө
	Химийн бодис алдагдана		4	4	IV	Аюултай бодисын хяналт, бүртгэл
			4	4	IV	Ажлын байрны эмх цэгц

¹ Үр дагавар: 1

² Эрсдэлийн зэрэглэл: I – Бага, II – Дунд, III – Өндөр, IV – Маш өндөр

Нүүрсний овоолго байгуулах	Бутарсан нүүрс овоологдох	Хүлэмжийн хий үүснэ	1	2	II	Уурхайн төлөвлөлт
	Нүүрс газрын гадаргад гарна	Тоос үүснэ	5	4	IV	Тоос бууруулах арга хэмжээ
			5	4	IV	Дэвшилтэт технологи судалгаа
			5	4	IV	Аэрозолын хяналт
Оффисын байрны үйл ажиллагаа	Дулааны хэрэглээ	Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Мод тарих
			4	1	II	Түлш зарцуулалтын хяналт
Тэсэлгээ явуулах	Чичиргээ, дуу чимээ	Ард иргэдийн тав тух алдагдана	1	3	II	Нөхөн олговор
			1	3	II	Дуу чимээний хяналт
			1	3	II	Дуу чимээ тархалтын судалгаа
Ус хангамж /ахуй/	Ус хэрэглэх	Усны эх үүсвэр багасна	4	2	II	Усны хэрэглээний хяналт
Ус хангамж /үйлдвэр/			4	4	IV	Нөөцийн хэмнэлт
			4	4	IV	Усны хэрэглээний хяналт
Уулын цулын тээвэр	Гадарга дээр зам үүсгэх	Хөрсний эвдрэл	3	2	II	Хаалтын зөв төлөвлөлт
			3	2	II	Геоэкологи орчны хяналт
	Техникийн хөдөлгөөн	Тоос үүснэ	5	5	IV	Тоос бууруулах арга хэмжээ
			5	5	IV	Аэрозолын хяналт
			5	5	IV	Дэвшилтэт технологи судалгаа
			5	5	IV	Тоос бууруулах арга хэмжээ
Уурхайн барилга байгууламж	Орогнох зай бий болно	Хортон амьтан үүрлэх, олшрох	2	4	II	Барилга барихаас өмнө дизайныг бодолцох
Хоол үйлдвэрлэл	Хог хаягдал үүснэ	Лэндфилийн талбай нэмэгдэнэ	5	2	III	Хог хаягдлыг ангилан ялгалт, дахин боловсруулалт
			5	2	III	Хог хаягдлын гарцыг хянах
Хөрс хуулалт	Уулын ахилт	Хүлэмжийн хий үүснэ	4	2	II	БОЯБ дүйцүүлэн хамгаалах
			4	2	II	Хүлэмжийн хийн хяналт
	Уулын ахилт, мөргөцөгөөс олборлох	Тоос үүснэ	5	4	IV	Тоос бууруулах арга хэмжээ
			5	4	IV	Аэрозолын хяналт
			5	4	IV	Дэвшилтэт технологийн судалгаа
	Ухаш үүснэ	Аюултай гео орчин үүснэ	5	2	III	БОЯБ дүйцүүлэн хамгаалах

			5	2	III	Геоэкологи орчны хяналт
		Хөрсний эвдрэл	5	3	IV	БОЯБ дүйцүүлэн хамгаалах
Хөрсний овоолгын ажил	Чулуулаг газрын гадаргад гарч өгөршилд орно	Тоос үүснэ	4	3	III	Нөхөн сэргээлт явуулах
			4	3	III	Аэрозолын хяналт
	Чулуулаг устай харилцах	Хүчлийн урсац үүснэ	3	2	II	Нөхөн сэргээлт явуулах
			3	2	II	Геохимийн хяналт
Цахилгааны хэрэглээ, оффис байр	Цахилгаан хэрэглэх	Хүлэмжийн хий үүснэ	5	1	II	Нөөцийн хяналт
			5	1	II	Цахилгааны хэрэглээний хяналт
Цахилгааны шугам	Шувууны анхааралд өртөнө	Шувуу эндэх	3	4	IV	Дизайны сайжруулалт
			3	4	IV	БОЯБ мониторинг

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгойн нүүрсний орд газар дахь ил уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- ISO 14001:2015 байгаль орчны удирдлагын тогтолцооны элементүүдийг хэрэгжүүлэх
- Байгаль орчны аудит, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх
- Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах
- Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах,
- Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарч ажиллах
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлого, дүрэм, журмыг хэрэгжилтийг хангах
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх.
- БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох
- ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах.

5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар							
5.1.1	Уурхайн уулын цул тээвэрлэх үйл ажиллагаанаас агаарт тоос үүсэх	Тоос бууруулах бодисыг технологийн замд ашиглана.	Уурхайн технологийн зам	10 км	Жилийн турш	124.0	Агаарын тухай хууль, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)
5.1.2	Уурхайн олборлолт болон хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Уурхайн ашиглалтын замыг сайжруулах: материал, дэвсэлт хийх	Уурхайн технологийн зам, талбай	10 км	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Агаарын тухай хууль, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)
5.1.3		Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах	Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбай	5-аас доошгүй	Жилийн турш		
5.1.4		Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих	Уурхайн технологийн зам	Сард 3	Жилийн турш		
5.1.5	Хотхон уурхайг холбосон шороон замаас тоосжилт бий болох	7.4км ачаа тээврийн сайжруулсан шороон замын засвар үйлчилгээ, арчилгааг батлагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэх, цаашид хатуу хучилттай болгох ажлыг санаачлан зохион байгуулах	Кемп хоорондын шороон зам болон ачаа тээврийн сайжруулсан шороон зам	7.4км	Жилийн турш		
5.1.6	Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Нүүрс ачилтын талбай	Тогтмол	Жилийн турш	-	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
5.1.7		Нүүрс ачилтын талбайд усалгаа хийх	НАБТ	Тодорхойл ох боломжгүй	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-Х02 ³
5.1.8	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүр болон нам даралтын зуухны яндангаар хорт хий ялгарч агаар орчныг бохирдуулах	Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгсэл	-	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	
5.1.9		Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих	Цанхи хотхон болон Грийн центрийн уурын зуух	2	Жилд 1 удаа	-	
5.1.10	Агаарын чанарын хяналт	Агаарын чанарын суурин станцны худалдан авалтыг хийж, БОАЖГ-т дүн мэдээг онлайнаар өгч байх	Уурхай орчимд	1	Жилийн турш		
Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
Гадаргын ба газрын доорх усны нөөц							
5.2.1	Газар доорх усны бохирдол үүсэх	Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.	Эзэмшлийн худгууд	Нийт худаг	Жилийн турш	-	Ус ашиглалтын журам ЭТТ-СА-Ж38-БО-Ж11-Х01

³ Агаарын чанарын хяналт хийх горим.

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
5.2.2	Газар доорх усны нөөц хомсдох	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авах, ус ашиглах гэрээ байгуулах	Уурхайн хэмжээнд	1	2024 оны 1-р улиралд багтаан	Үйл ажиллагааны зардал	Усны тухай хууль
5.2.3		Усны нөөц ашигласны төлбөр төлөх, ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах	Уурхайн хэмжээнд	12	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Усны тухай хууль
5.2.4		Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх	Цэвэрлэх байгууламжууд	4	Улирал бүр	Үйл ажиллагааны зардал	Ус бохирдуулсны тухай хууль
5.2.5		Зам усалгаанд гадаргын усыг түлхүү ашиглах, усны хэрэглээг багасгах	ЭТТ, гэрээт компаниуд	-	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Усны тухай хууль, Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
5.2.6		Хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх, стандарт шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглах	ЭТТ, гэрээт компаниуд	Тодорхойлох боломжгүй	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	
5.2.7	Газар доорх усны нөөц хомсдох	Уурхайн газар доорхи усны нөөц, чанарт байнгын хяналт тавих	GW713, №21, 2	3	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	
5.2.8	Гадаргын усны нөөцийг хамгаалах	Булгийн эхийг сэргээх, хашиж хамгаалах /Мухар гашуу булаг/	ЭТТ, гэрээт компаниуд	1	III улиралд	Үйл ажиллагааны зардал	
Хөрсөн бүрхэвч							

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
5.3.1	Уурхайн хэмжээнд хөрсний доройтол бохирдол үүсэх	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах	Уурхайн хэмжээнд	12	Сар бүр	-	Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х02
5.3.2	Хөрсний үржил шим алдагдах	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарих	Уурхайн хэмжээнд	>3 га	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт MNS 5917:2008. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага.
5.3.3	Тусгай зөвшөөрлийн талбайд зөвшөөрөлгүй ААН үйл ажиллагаа явуулж хөрсий элэгдэл эвдрэл, бохирдол үүсгэх	Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	1	Жилд 1 удаа	-	Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х01
5.3.4	Ил уурхай, хаягдал чулуулгийн гадаад овоолгын шимт хөрс олборлолтод өртөх	Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Тухай бүр	Жилийн турш	-	Газрын тухай хууль, MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
5.3.5		Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах	Уурхайн хэмжээнд	Овоолгын дүүрэлтээс шалгаална	Жилийн турш	-	MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
5.3.6		Уурхайн хэмжээнд шимт хөрсний судалгаа хийж зөөгдөөгүй үлдсэн шимт хөрсийг зохих овоолгод байршуулах	Уурхайн хэмжээнд	-	Жилийн турш	-	
Газрын хэвлий							

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
5.4.1	Олборлолтын улмаас газрын хэвлий эвдрэх, нөлөөлөлд өртөж доройтох.	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Олгосон Зөвшөөрлийн тоо	Тухай бүр	-	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Газар хөндөх” журам
5.4.2		Тусгай зөвшөөрлийн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын явуулж буй ААН судалгаа хийх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	-	Улиралд 1 удаа	-	Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай
Ургамлан нөмрөг							
5.5.1	Уурхайн ахилт, тэлэлтэд ховор болон нэн ховор ургамал өртөх	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгах	Тухайн жилийн ахилтын хүрээ	Мониторингийн судалгаа	6-8-р сарын хооронд	-	Ургамал хамгааллын тухай хууль, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Газар хөндөх болон ховор, нэн ховор ургамлыг хамгаалах журам
5.5.2		Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Ажилтнуудад	>500 ажилтан	Жилд 1 удаа	-	Байгалийн ургамлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль
Амьтны аймаг							

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал сая ₮	Эрх зүйн баримт бичиг
5.6.1	Уурхайн үйл ажиллагаанаас нутгийн зэрлэг амьтдын тоо толгой багасах	Тус бүс нутагт өвөлжилт, хаваржилт хүндэрч, зэрлэг амьтдын идэш тэжээл ховордох тохиолдол гардаг тул зэрлэг амьтдад өвс, мөс тавих ажлыг зохион байгуулах	Цогтцэций сум	>300 боодол	9 удаа	8.7	Амьтны тухай хууль, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр, Орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээ
5.6.2	Өндөр хүчдэлийн шугаманд шувуу өртөж тоо толгой багасах	Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамаар хяналт хийх, шаардлагатай тохиолдолд нэмж шувуу үргээгч байршуулах	Уурхайн хэмжээнд	50 км	VII сард	-	Амьтны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
5.6.3	Хууль бус ан зэрэг шууд нөлөөллийн улмаас ан амьтдын нөөц нь багасах	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Төслийн хэмжээнд	1000 хүн	Жилд 2 удаа	-	
5.6.4		Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулахад орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	Орон нутаг	-	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Амьтны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль

5.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

5.1.1 Тоос бууруулах технологийн ажил

2020-2023 оны аэрозолийн хэмжилтийн үр дүнгээс харахад уурхайн тоосжилтыг усаар багасгах арга нь төдийлөн үр дүнгүй байгааг илтгэж байна.

Уурхайн шууд болон шууд бус үйл ажиллагаа буюу нүүрс олборлолт, ачилт, тээвэрлэлтээс үүдэлтэй тоосжилтыг бууруулах технологийн хувилбаруудыг судлан сонгож туршилтаар бататган эдийн засгийн тооцоонд үндэслэн хамгийн үр дүнтэй аргачлалыг Эрдэм шинжилгээний байгууллага эсвэл мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж уурхайн үйл ажиллагааны нэг хэсэг болгон нутагшуулахыг зорино.

Цанхийн уурхайнуудын технологийн замын 10 км замд бодисыг ашигласан байна. Үүнээс Цанхийн зүүн уурхайн технологийн замын 6 км-ээс багагүй замд, Цанхийн баруун уурхайн технологийн замуудын 4 км-ээс багагүй замд тоосжилт бууруулах бодис ашиглаж тоосжилтийн түвшинг бууруулна.

5.1.2 Уурхайн ашиглалтын замыг сайжруулах

Тоосжилтыг бууруулах зориулалтаар уурхайн худгуудын усыг зам, талбайг чийглэх уламжлалт аргыг хэрэглэнэ. Мөн уурхай болон хөрсний овоолгын ачаалал ихтэй, тоосжилт ихээр үүсгэж буй зам талбайг тодорхойлж техникийн хөдөлгөөнөөр тоос бага үүсгэдэг материалын дэвсэлт хийнэ. 18 м өргөнтэй Цанхийн баруун уурхайд 6 км, Цанхийн зүүн уурхайд 4 км тус тус урттай замын хэсэгт дэвсэлт хийгдэнэ. Ажлын хэмжээ 10 км.

Аюулгүй ажиллагааг хангах халтиргаа гулгаанаас сэргийлэх зорилгоор зам талбайн усалгааг ихэнхдээ дулааны улирал буюу гадаргуу дээр ус хөлдөхөөргүй гадаад орчны нөхцөлд хийдэг. Зам талбайн усалгаанд худгийн усыг аль болох бага, хур тунадсаар газрын гадаргад хуримтлагдсан усыг түлхүү ашиглахыг зорино.

5.1.3 Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах

Уурхайн хэмжээнд 5-аас доошгүй усалгааны машиныг жилийн турш тогтмол усалгаанд ашиглана. Цанхийн зүүн уурхайд 2-оос доошгүй усны машиныг жилийн турш тогтмол, Цанхийн баруун уурхайд 2-оос доошгүйг, Нүүрс ачилтын хэсэгт 1-ээс доошгүйг тогтмол ашиглаж ажиллана.

5.1.4 Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих

Сар бүр уурхайн хөдөлгөөнт техникүүдэд хяналт шалгалтыг Уурхайн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнүүдийн хамтаар тогтмол хийж гүйцэтгэн бүртгэл хөтлөж зөвшөөрөгдсөн хэмжээнээс хурдыг хэтрүүлсэн ажилтнуудад арга хэмжээ авч нийтэд мэдээлэх байдлаар хурдны хязгаарыг байнга мөрдүүлж ажиллана.

5.1.5 Туслах шороон замуудын нөхцөлийг сайжруулах чиглэлийн ажил

Цогтцэций сумын засаг даргын 2022 оны 11-р сарын 28-ний өдрийн 1/637 тоот албан бичгийн дагуу батлагдсан зам арчилгааны хуваарыг туслан гүйцэтгэгч гэрээт компаниудтай хамтран Тавантолгой түлшийн нүүрс тээврийн 7.4 км шороон замын засвар арчилгаа, усалгааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Тус замыг цаашид хүнд даацын хатуу хучилттай засмал зам болгох саналыг холбогдох хэлтэс нэгжид хүргүүлэн ажиллана.

5.1.6 Нүүрс тээвэрлэлтийн машинуудын хяналт

Нүүрс тээвэр, ложистикийн хэлтэстэй хамтран нүүрс тээвэрлэлт хийж буй машинуудыг бүтээлэгтэй байлгаж, зөвшөөрөгдсөн замын маршрутын дагуу тээвэрлэлт хийж байгаа эсэхэд тогтмол хяналт хийж ажиллана.

5.1.7 Нүүрс ачилтын талбайд усалгаа хийх

Нүүрс ачилтын талбайд 2-оос доошгүй усны машин ажиллуулж, усалгааг тогтмол хийнэ.

5.1.8 Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах

Үйлдвэрлэл техникийн газрын Засвар механикийн хэлтэстэй хамтран уурхайн ажилд ашиглагдаж буй автомашинуудыг тээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулах ажиллана. Мөн дотооддоо техникийн үзэг шалгалтыг хуваарь гаргаж долоо хоног бүр хамруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх дээр хяналт тавьж ажиллана.

5.1.9 Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих

Цанхи хотхон болон Грийн центрийн уурын зуухнаас ялгарах утааны шинжилгээний хэмжилтийг итгэмжилсэн лабораторид шинжлүүлж стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллана.

5.1.10 Агаарын чанарын хяналт

Агаарын чанарын суурин 1 ширхэг станцны худалдан авалтыг хийж, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт дүн мэдээг онлайнаар өгч ажиллана.

5.2 Усан орчинд учруулах нөлөөллийг багасгах төлөвлөгөө

5.2.1 Газар доорх усны бохирдлоос хамгаалах

Газар доорх усны бохирдол үүсэхээс хамгаалж худгийн хийц, хамгаалах байр, тоноглолд тусгай шаардлага тавьж хяналттай байлгана. Хяналт, зохицуулалтыг дотоодын журмаар (ЭТТ-СА-Ж09-БО-Ж05-Х02 Худаг, уст цэгт засвар үйлчилгээ хийх журам) хэрэгжүүлж ажиллана.

Худгуудад байршуулсан усны тоолуур гэмтэх, эвдрэх, тоолуурын гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд сумын Байгаль орчны улсын байцаагчид мэдэгдэж, түүний хяналтан дор лацыг хөндөж, засвар үйлчилгээг хийх, стандарт хэмжилзүйн газраар баталгаажилт хийлгэсэн тоолуурыг суурилуулна. Ус ашиглагч болон байгаль орчны улсын байцаагч нарыг байлцуулан акт үйлдэж баталгаажуулсан байна. Засвар үйлчилгээ хийх явцад худгаас зайлшгүй ус авч ашиглах тохиолдолд усны машины рейсийг үнэн зөв бүртгэж сар бүрийн усны актад тусгана.

5.2.2 Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх

Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж дүгнэлтэнд заагдсаны дагуу холбогдох гэрээг байгуулж төлбөрийг сар бүрийн тоолуурын заалтыг сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулж төлбөрийг тогтмол хугацаанд нь төлсөн байна.

5.2.3 Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх

Сав газрын захиргаанаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авч, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулан улирал бүрийн дүгнэлтийг үндэслэн зохих төлбөрийг улирал бүр төлнө. Хаягдал усыг зөвшөөрөгдсөн цэгт нийлүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг гэрээт компаниудад үүрэг болгож, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана. Мөн цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэршүүлсэн бохир ус нь стандартад нийцэж байгаа эсэхийг улирал тутамд хянаж, итгэмжлэгдсэн лабораторид усны дээжийг шинжлүүлэх ба шинжилгээний дүнд үндэслэн уурхайн зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглана.

5.2.4 Замын тоосжилт бууруулахад ашиглах гадаргын болон гүний усны харьцааг 0.32-аас бага түвшинд байлгах

Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй уст цэгүүдийн хэвийн ажиллагааг хангах, компанийн ус ашиглалтын нормыг тогтоох, ус ашиглах боломжит нөөцийн хүрээнд үр

ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох үүднээс компанийн хэмжээнд мөрдөгдөх “Ус ашиглалтын журам”-ыг дотооддоо боловсруулж, батлуулан мөрдөж ажиллана.

Уурхайн ус ашиглалтын тайланг жилд 2 удаа боловсруулах ба холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангана. Жилийн эцэст “Ус ашиглуулах гэрээ”-г сав газрын захиргаатай хамтран дүгнэж акт үйлдсэн байна.

Шинээр уст цэг гаргах тохиолдолд Сумын ЗДТГ-аас уст цэг өрөмдөх зөвшөөрлийг авсны үндсэн дээр сав газрын захиргаанаас цооног өрөмдөх зөвшөөрлийг авна.

Зам усалгаанд ашиглаж байгаа газар доорх усны хэмжээг бууруулах зорилгоор борооны усаар хуримтлагдсан усыг тоос бууруулах зориулалтаар түлхүү ашиглахыг зорино.

5.2.5 Бохир усыг зөвшөөрөлтэй газар нийлүүлэх, саарал усыг дахин ашиглах

Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх түүнд хяналт тавих, стандарт шаардлагад шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглана.

5.2.6 Уурхайн газар доорхи усны нөөц, чанарт байнгын хяналт тавих

Уурхайн газар доорхи усны мониторингийн цооногуудад түвшний хэмжилт хийх, усны чанарыг лабораторид шинжлүүлнэ.

5.2.7 Булгийн эхийг хамгаалах

Цогтцэций сумын нутагт байрлах Мухар гашуу булгийн эхийг сэргээх, хашиж, хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, орон нутагт хүлээлгэн өгнө.

5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

5.3.1 Нүүрс устөрөгчийн хяналтгүйгээс хөрс бохирдох

Уурхайд технологийн горим алдагдах зэрэг шалтгаанаар асгаралт түгээмэл тохиолддог. Нүүрс-устөрөгчийн болон химийн бодисын удирдлагын тогтолцооны хүрээнд асгаралтын иж бүрдэл байршуулж асгаралтын үед авах арга хэмжээг мөрдөж ажиллана. Асгаралтын үр дагаврыг багасгах, сэргийлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ажлын байрны үзлэг болон техникийн тойрох үзлэг шалгалтаар асгаралт үүсэх өндөр магадлалтай техник төхөөрөмж, объектуудад урьдчилсан үзлэг хийж хариу арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.
- Асгаралт гарсан тохиолдолд нөлөөллийг хязгаарлах, орчин тойрныг бохирдуулахгүй байхад бэлэн байх нөхцөлийг хангаж асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгана.
- Саармагжуулах бодисын бэлэн байдлыг бэлэн байлгах, асгаралт үүсч болзошгүй засварын төв зэрэг барилгуудад асгаралтын иж бүрдлийн бэлэн байдлыг нөөцлөх шаардлагыг чандлан мөрдөнө.
- Асгаралт үүссэн тохиолдол бүрийг бүртгэж цаашид ямар арга хэмжээ авснаар илүү үр дүнтэй байх дүгнэлт боловсруулж суралцан хөгжих тогтолцоог хэрэгжүүлнэ.

5.3.2 Технологийн горимын мөрдөлтийг хангуулах ажиллагаа

Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимыг хангуулж байгаль орчны чиглэлийн дотоодын журам, горимуудыг мөрдөнө.

- Уурхайн хэмжээнд Ажлын байрны үзлэгийг тотмол хугацаанд хийж аливаа үл нийцлийг илрүүлж арилгах хариу арга хэмжээ авна
- Компанийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах. /ЭТТ-СА-Ж14-БО-Ж09-ХОЗ/

- Гэрээтүүдийн сар бүрийн KPI /сар бүрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх/
Гэрээт компаниудад зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлээгүй тохиолдолд зөрчилд тооцно

5.3.3 Хөрсний үржил шим алдагдах

Цанхийн уурхайнуудын шимт хөрсний насжилтыг тодорхойлох, шимт хөрсний овоолгыг үе шаттайгаар стандартын дагуу олон наст ургамал тариж хамгаалах, хадгалах ажлын хүрээнд Цанхийн уурхайнуудын шимт хөрсний овоолгуудаас дүүрсэн, овоолгын хэлбэржүүлэлтийг бүрэн хийж дуусгасан 3 га-гаас багагүй талбайтай шимт хөрсний овоолгын гадаргууг үржил шимийг алдагдахаас сэргийлэх зорилгоор олон наст ургамлын үр тариалж хамгаална.

5.3.4 Тусгай зөвшөөрлийн талбайд зөвшөөрөлгүй ААН үйл ажиллагаа явуулж хөрсий элэгдэл эвдрэл, бохирдол үүсгэх

Уурхайн дотоод талбайд олон салаа шороон зам гаргахаас урьдчилан сэргийлж уурхайн дотоод ашиглалтын замын трассыг албан ёсоор баталгаажуулж, шинээр гарсан технологийн замыг тэмдэгжүүлэх, хурдны хязгаарт хяналт тавих ажлыг сар бүр тогтмол хийж хэрэгжүүлнэ.

5.3.5 Ил уурхай, хаягдал чулуулгийн гадаад овоолгын шимт хөрс олборлолтод өртөх

Уурхайн ахилт, зам талбай болон, хөрсний овоолгод хийгдэх ажлын үеийн шимт хөрсийг хуулж стандартын дагуу хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ. Тус ажлыг гүйцэтгэхдээ компанийн салбарын захирлын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/393 дугаар тушаалаар баталсан /ЭТТ-СА-Ж41-БО-Ж09-Х03/ “Өнгөн хөрстэй ажиллах журам” /ЭТТ-СА-Ж11-БО-Ж07-Х03/ “Газар хөндөх” журмыг баримтлал болгон ажиллана. Мөн тухайн жилийн газар хөндөх болон, шимт хөрс хуулах зөвшөөрлийн бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлж хадгална.

Уурхайн ахилт, зам талбай, хөрсний овоолгын тэлэлтийн шимт хөрс хуулах ажлыг Өнгөн хөрстэй ажиллах журам /ЭТТ-СА-Ж41-БО-Ж09-Х03/, Газар хөндөх журам /ЭТТ-СА-Ж11-БО-Ж07-Х03/-ын батлагдсан маягтын дагуу олгож, олгосон зөвшөөрлийн дагуу бүртгэлийг хийж, хяналт тавьж ажиллана.

Шимт хөрс байрлуулсан талбай дүүрсэн тохиолдолд Маркшейдэр инженерийн хэмжилтийн дүн болон /ЭТТ-СА-Ж41-БО-Ж09-Х03/ “Өнгөн хөрстэй ажиллах журам”-ыг баримтлан акт үйлдэн хаана.

5.4 Газрын хэвлийд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

5.4.1 Журмын хэрэгжилтийг хангах

Газар хөндөх үйл ажиллагааг хяналттайгаар явуулах зорилгоор газар хөндөх зөвшөөрлийг баталсан журам, зохион байгуулалтын дагуу хэрэгжүүлэн, газар хөндөх зөвшөөрлийн үйл явцад сайжруулалт хийж газрын хэмжээг GIS систем болон нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

5.4.2 Олборлолтын улмаас газрын хэвлий эвдрэх, нөлөөлөлд өртөж доройтох

Холбогдох зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахгүй байлгах үүднээс Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам /ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х01/-ын дагуу тогтмол хяналт хийнэ.

5.5 Ургамлан нөмрөгт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

5.5.1 Нэн ховор, ховор ургамлыг шилжүүлж суулгах

Монгол улсын хэмжээнд байгалийн жамаар нөхөн сэргэх, чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй устах аюулд орсон 133 зүйлийн нэн ховор ургамал, байгалийн жамаар нөхөн сэргээгдэх чадавх нь хязгаарлагдмал, нөөц багатай устаж болзошгүй 355 зүйлийн ховор гуурст дээд ургамал бүртгэгдсэн байдаг. Монгол орны

ургамлын аймагт 1000 орчим зүйлийн эмийн, 200 гаруй хүнсний, 200 орчим техникийн 150 гаруй витаминт, 200 гаруй будагт, 100 орчим чимэглэлийн, 1000 гаруй тэжээлийн ач холбогдолтой ашигт ургамал байдаг.

2024 онд Уурхайн ахилтын 10 жилийн хүрээний дагуу нэн ховор, ховор ургамлын судалгааг хийхээр төвлөж байна. Хугацаа нь 7 дугаар сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 20-н хооронд гүйцэтгэнэ. Энэ нь тухайн бүс нутгийн төлөөлөл болсон ашигт ургамал бүхий бүлгэмдэлд геоботаникийн бичиглэл, судалгаа хийх нь тэдгээрийн хөдлөл зүй, хамгаалах, ашиглах арга замын боловсруулахад чухал шаардлагатай мэдээллийн бааз суурь болно. Геоботаникийн бичиглэл хийхдээ ургамлын тусгаг бүрхэц, өндөр, үзэгдэл зүйн үе шат үндсэн үзүүлэлтийг хэмжэнэ. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийн талбайд нэн ховор, ховор ургамлын тархацын судалгааг хийж, координат цэгийг тэмдэглэх;
- Фото зургаар баталгаажуулан, ургамлын хамтаамал бэлтгэх;

5.5.2 Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах

Эрдэнэс Тавантолгой ХК болон туслан гүйцэтгэгч гэрээт байгууллагын ажилчдад тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор ургамлын төрөл зүйл, эмийн ургамлын хэрэглээ, хоруу чагарын тухай мэдлэг болно. Мөн Байгалийн ургамлын тухай хууль, Зөрчлийн тухай хуульд ховор, нэн ховор ургамлыг зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн тохиолдолд хүлээх хариуцлагын тухай сургалтын материал боловсруулж сургалт орно.

5.6 Амьтны аймагт учруулах сөрөг нөөлөөлийг бууруулах төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны шууд болон дам нөлөөллөөр биологийн олон янз байдалд өртөх эрсдэлээс хамгаалах аргыг тодорхойлохын тулд өртөлтийн судалгааг сайтар хийсэн байх шаардлагатай. Мониторингийн хөтөлбөрөөр экологийн ач холбогдолтой амьтны аймгийн гол хүрээний зүйлүүдийн тооллого, судалгааг дотоод бололцооны дагуу хийж гүйцэтгэж байна. БОЯБ судалгааг цаашид мэргэжлийн түвшинд явуулах шаардлага байна.

5.6.1 Биотехникийн арга хэмжээ

Техноген нөлөөгөөр амьдрах нутаг хязгаарлагдаж байгаа туруутан болон махчин амьтдын популяцад учруулж буй нөлөөг сааруулах зорилгоор биотехникийн арга хэмжээг орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан албан хаагч нартай хамтран авч хэрэгжүүлнэ.

5.6.2 Шувууны өртөлтийг багасгах арга хэмжээ

Цахилгааны шугам дагуу шувууны өртөлтийн судалгааг хийж, гарсан үр дүнд үндэслэн шаардлагатай газруудад стандарт шаардлагад нийцсэн шувуу үргээгч байрлуулна.

5.6.3 Хулгайн ангаас сэргийлэх сургалт зохион байгуулах

Төслийн хэмжээнд гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран хууль бус хулгайн антай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон хориотой ан амьтны талаарх сургалтыг зохион байгуулна.

5.6.4 Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулахад орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулах арга хэмжээний хүрээнд Цогтцэций сумын байгаль хамгаалагчтай хамтран судалгааны ажилд оролцох, шаардлагатай бензин, түлш болон багаж хэрэгслээр хангаж хамтран оролцохоор төлөвлөж байна.

6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, сая ₮	Эрх зүйн баримт бичиг
6.1.1	Техникийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	Тусгай зөвшөөрлийн талбайд	га	>3	II-III улиралд	Үйл ажиллагааны зардал	Газрын Тухай Хууль Газрын Хэвлийн Тухай Хууль 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS Нөхөн сэргээлт 2020-2024 хөтөлбөр
6.2.1	Биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл үе шат	Үрийн нөөц бүрдүүлэх	ЭТТ, гэрээт компаниуд	кг	10	Жилдээ	207.1	Ашигт малтмалын тухай хуулийн 39-р зүйл
6.2.2		Модлог ургамлын мөчир бэлтгэх,	ЭТТ	ш	>5000	I улирал		
6.2.3		Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бордоог нөхөн сэргээлтэд ашиглах	Үрсэлгээний талбай	тн	тухайн жилд гарах хаягдлын хэмжээгээр	Жилдээ	26.0	

6.1 Техникийн нөхөн сэргээлт

6.1.1 Газрын элэгдэл эвдрэлийн судалгаа гаргах, техникийн нөхөн сэргээлт хийх.

Цанхийн зүүн болон, баруун уурхайн талбайн хэмжээнд үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж ашиглагдахгүй болсон газрын судалгааг, гэрээт туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран гаргана. Судалгаанд үндэслэн техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, шаардлагатай талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж эхлэнэ.

6.2 Биологийн нөхөн сэргээлт

6.2.1 Үрийн нөөц бүрдүүлэх ажил

Байгалийн ургамлын үрийн нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд 10 кг-аас багагүй нутгийн ургамлын үрийг түүж хадгална. Говийн нөхцөлд ургахад тохиромжтой нутгийн бэлчээрийн олон наст ургамал болон мод, сөөгний үрийг 2024 онд үрслүүлж цаашид тарьж ургуулан биологийн нөхөн сэргээлтийн ажилд ашиглахаар төлөвлөж байна.

6.2.2 Модлог ургамлын мөчир бэлтгэх

Сэжмээр ургах боломж бүхий модлог ургамлын мөчир бэлтгэх ажлын хүрээнд 5000-10000 ширхэг мөчир бэлтгэж хадгална. Хадгалсан мөчрийг 2025 оны хавар “Эрдэнэс агропарк”-д үржүүлж тарьц суулгац үржүүлэх ажилд ашиглахаар төлөвлөж байна.

6.2.3 Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бордоог нөхөн сэргээлтэд ашиглах

Компост бордоо нь органик био гаралтай түүхий эдийг ашиглаж, ялзруулан задлах, эрдэсжүүлэх ялзмалжуулах гүмины бодисыг хуримтлуулах процессийг аэроб микро организмийн тусламжтайгаар явуулж бэлтгэсэн бордоог хэлнэ. Уг бордоог боловсруулахад ажилдчын хотхоны гал тогооноос гарч буй хүнсний хаягдлыг ашиглана. Цэцэрлэгжүүлэлтийн үлдэгдэлд / хугарсан мөчир, хатсан навч, холтос/, хог ургамал гэх мэтийг ашиглан био компост бордоог гарган авч мод үржүүлэгт ашиглана.

7 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

Ил уурхайн олборлолтын үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй газар нутгийн биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа нэн тэргүүнд нөлөөллөөс зайлсхийх, бууруулах нөхөн сэргээх арга хэмжээ хийгдэнэ. Мөн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг шат дараатайгаар хийж гүйцэтгэж байна.

Бүлэг	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, сая ₮
7.1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах, талбайг нэмэгдүүлж шинэчлэн гаргах	Дүйцүүлэн хамгаалах газар нутагт	-	-	I улирал	365.0
7.2		2023 оны ДХТ-г бүрэн хэрэгжүүлж дуусгах		ш	1	III улирал	
7.3		Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх		-	-	Жилийн турш	

		хамтарсан багийг орон нутагтай хамтран ажиллуулах, дэмжлэг үзүүлэх					
7.4		2024 оны ДХТ-г гаргаж хэрэгжилтийг ханган ажиллах				III улирал	
7.5		Бэлчээр хашиж, ургамлын нөмрөгийг сайжруулах		га	2	II-III-р улирал	

7.1 Урт хугацааны төлөвлөгөө гаргах

Дүйцүүлэн хамгаалан талбайд цаашид хэрэгжүүлж ажиллах дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, талбайн хэмжээг шинэчлэн гаргуулна.

7.2 Өмнө жил хийгдсэн ажлыг эцэслэх

2023 онд Дүйцүүлэн хамгаалах талбайн байршилд хийгдсэн ажлыг эцэслэж тайланг боловсруулан мэдээ тайланг нэгтгэн ажиллана.

7.3 Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх

Зэрлэг ан амьтдыг хамгаалах ажлын хүрээнд сум орон нутгийн экологийн цагдаагийн албатай хамтарсан багийг ажиллуулж шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэн ажиллана. Мөн амьтдыг хамгаалах зорилгоор 24 цагийн мэдээллийн утасыг ажиллуулж экологийн цагдаад мэдээллэнэ.

7.4 2024 оны төлөвлөлтийг гаргах, хэрэгжүүлэх

2024 оны хэмжээнд хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллана.

7.5 Ургамлын нөмрөгийг сайжруулах

Дүйцүүлэн хамгаалах талбайд ургамлан нөмрөгийг сайжруулах зорилгоор 2 га газрыг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

8 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Өмнөговь аймгийн нутгийн захиргааны байгууллагад Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар ханган, иргэдийн хөрөнгийн нөхөн олговрыг олгох, газар чөлөөлөх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахад хамтрах ажиллах хүсэлтийг Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. Зардал нь “Эрдэнэс Тавантолгой хөгжлийн сан”-аас гарна.

Бүлэг	Нөлөөлөлд өртөх иргэд,	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Нийт зардал ⁴ , сая ₮
-------	------------------------	-------------------------------	----------------------------	------------	--------------------------------	---------------------------------	----------------------------------

⁴ Орон нутгийн сан

81	Цагаан овоо баг	Цагаан овоо багийн иргэдтэй гэрээ байгуулах, нөхөн олговор олгох	Тосгоны иргэд	40 иргэн	2024 онд	Нийгмийн хамгааллын бодлого, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, ЗГ-ын 182 тогтоол, БХБС-ын 203 тушаал	Тодорхойлох боломжгүй
----	-----------------	--	---------------	----------	----------	--	-----------------------

9 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/141 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн судалгаа хийх журам”-д нийцүүлэн археологи, палеонтологийн хайгуул, авран хамгаалах судалгааг мэргэжлийн байгууллагаар жил бүр шат дараатайгаар хийлгэсэн ба Цанхийн болон Бортээгийн бүх хэсэгт археологийн авран хамгаалах малтлага судалгаа хийж талбайг чөлөөлсөн.

Цаашид Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад өмнө хийгдсэн хайгуулаар илрээгүй түүх, соёлын дурсгалт зүйл олдсон тохиолдолд олборлох ажлаа зогсоож энэ тухай, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэн ажиллах болно.

Соёлын биет бус өвийг хамгаалах

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд "Ард түмний билэг авъяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, дэг сургууль, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараахь оюуны соёлын үнэт зүйлийг соёлын биет бус өвд хамааруулна." гэж заасан байдаг. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалын 1-р хавсралтаар батласан Монгол Улсын биет бус соёлын өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд 7 айн 279 өв багтсан байдаг ба Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд “Монгол шагайн харваа” багтсан байдаг.

Монгол шагайн харвааг Цогтцэций сумын иргэд болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ажилчдын дунд түгээн дэлгэрүүлэх, залуу үед өвлөн үлдээх ажлын хүрээнд 2024 онд Цогтцэций суманд Монголын шагайн харвааны холбооны Салбар зөвлөлийг байгуулан ажиллахаар төлөвлөж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ажилчдын дундах шагайн харвааны сонирхогч клуб нь 52 гишүүнчлэлтэй бөгөөд Цогтцэций сумын 18-н харваач байна. Мөн тус клубт Монгол улсын шагайн харвааны холбооны тэргүүлэгч гишүүн бөгөөд Монгол Улсын Үлэмж Дархан мэргэн, Спортын мастер Т.Ганбүргэд, Монгол Улсын Үлэмж дархан мэргэн Д.Од-Эрдэнэ зэрэг улс, аймгийн цолтой олон мэргэн харваачид байдаг.

10 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
10.1.1	Нүүрс устөрөгч, Химийн бодис хяналтгүйгээгээр асгарах	ХАЛМ-ийг химийн бодис ашигладаг ажлын байруудад байрлуулах, сургалт зохион байгуулах.	Уурхайн хэмжээнд	-	>500 хүнд	Жилд 2 удаа	Асгаралтын журам
10.1.2		Асгаралтыг бүртгэлжүүлж тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах		Тодорхойлох боломжгүй		Тухай бүр	
10.2.1	Байгалийн аюул, гамшиг нөхцөл байдал	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах.	Уурхайн хэмжээнд	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль
10.2.2		Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	Уурхайн хэмжээнд	-	>800 хүнд	Жилд 2 удаа	
10.2.3		Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	Уурхай, хотхоны хэмжээнд	-	-	Жилийн турш	Усны тухай хууль, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм, БНБД-30.01.03
10.3.1	Гал түймрийн аюул эрсдэл	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх.	Уурхайн хэмжээнд	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
10.3.2		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих.	Уурхайн хэмжээнд	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль
10.3.3		Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг, шуудууг татах, сэргээх	ШТС-ын талбай	ш	5	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль, MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем, галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.
10.4.1	Байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэл	Хөрсний нуралтаас урьдчилан сэргийлэхийн тулд ил уурхайн хөрс хуулалт, шатлал, ухалт, тэсэлгээ зэрэг ажлуудыг гүйцэтгэхдээ холбогдох горимыг чанад мөрдөж ажиллах	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд	-	-	Жилийн туршид	Байгаль орчныг хамгаалах тухай хууль

11 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлын зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд төлөвлөгөөний зорилго оршино. Хүний амьдрах орчин, эрүүл мэндэд учруулах хог хаягдлын сөрөг нөлөөг илрүүлэн зохих арга хэмжээ авахад хэрэглээ, бүтээгдэхүүний сонголтыг харгалздаг дэлхий нийтийн хандлага бий болж байгаад анхаарна.

Энэхүү хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төслийн бүхий л үйл ажиллагаанаас гарч буй бүх төрлийн хог хаягдалд хамаарна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг энэхүү төслийн талбай дээр үйл ажиллагаа явуулж буй үндсэн болон гэрээт байгууллагууд дагаж мөрдөх үүрэгтэй.

Бүлэг	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
9.1.1	Аюултай хог хаягдал	Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу байгуулах	ЭТТ болон Цанхий баруун, зүүн уурхайд	3	II-III улирал	23.1	Хог хаягдлын тухай хууль
9.1.2		Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх.	ЭТТ болон гэрээт байгууллагууд	>5 удаа	Жилийн турш	80.3	
9.1.3		Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын талбайн стандартыг хангуулахад хяналт тавих	Цанхийн баруун, зүүн уурхайн гэрээт байгууллагууд	3 цэг	Жилийн турш	-	
9.2.1	Ахуйн хог хаягдал	Уурхайн хог хаягдлын түр цэг тогтоолгож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Уурхайн хэмжээнд	10 цэг	I-II-р улиралд	56.1	Хог хаягдлын тухай хууль
9.2.2		Хоол хүнсний хаягдал зайлуулж буй цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Ажилчдын хотхон	Улиралд 1 удаа	Жилийн турш		
9.2.3		Дахивар хаягдлыг ангилан ялгаж, хүлээн авах байгууллагад нийлүүлэх	ЭТТ болон бүх гэрээт	>5 тн	Жилийн турш		

9.2.4		Хог хаягдлыг урсгалыг хянах бүртгэлжүүлэх	Төслийн хэмжээнд	Нэгж тайлан	Жилийн турш	-	
9.2.5		Шаардлагатай байршлуудад хог хаягдлын ангилан ялгах савыг шинээр байршуулах, шинэчлэх	Уурхай, захиргааны байр	>100ш	I-р улиралд	-	
9.2.6		Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж тухай бүрт нь сумын төвлөрсөн хогийн цэгт буулган төлбөрийг төлж барагдуулах	ЭТТ ХК-ийн гэрээт болон туслан гүйцэтгэгч компани	-	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль
9.2.7		Хог хаягдлын ландфиллын талбай байгуулах газрыг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газрын зөвшөөрлийг авах, зураг төслийг боловсруулж эхлэх	Төслийн хэмжээнд	10 га	I-III-р улиралд	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль
9.2.8		Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу зогсоолын талбай байгуулах	Тээврийн зам дагуу	1	III-р улиралд	Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын тухай хууль
9.2.9		Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу талбайн үзлэгийг тогтмол зохион байгуулж, хяналт тавих	Тээврийн зам	12 удаа	Жилийн турш	-	Хог хаягдлын тухай хууль

11.1 Аюултай хог хаягдал

11.1.1 Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу байгуулах

ЭТТ ХК болон туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын хаягдал тосны байгууламжийг нэг цэгт төвлөрүүлэн стандартын дагуу байгуулсан байна. Хөрсөнд тос масло алдагдахаас сэргийлж бетонон суурьтай, халиагууртай хийнэ.

11.1.2 Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх

Эмнэлгээс үүсдэг хэрэглэгдсэн тариур, тариурын зүү, дуслын систем, хэрэгсэл, бохирдсон боолт, биеийн хэсэг, оношлогооны дээж, цус, химийн бодис, эм, эмнэлгийн багаж, цацраг идэвхт материалыг багтаана. Эдгээр хог хаягдлыг сум дундын эмнэлэгт хүргэж тусгай цэгт устгуулна.

Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй хог хаягдал устгах эрхтэй аж ахуйн нэгжид шилжүүлнэ. Техникийн тос материалаар бохирдсон шингээгч материал, алчуур, тосны шүүр, түлш, техникийн тосоор бохирдсон хөрс, химийн бодисын сав баглаа, боодлууд энэ ангилалд багтана.

11.1.3 Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын талбайн стандартыг хангуулахад хяналт тавих

Аюултай хог хаягдлын ангилан ялгалт, хадгалалтын стандартыг нийт уурхайн хэмжээнд мөрдүүлнэ. Гэрээт байгууллагууд туслан гүйцэтгэгчдэд тавих хяналтыг өргөжүүлэх зорилгын хүрээнд ажиллахыг уриалж шаардлага тавьж ажиллана.

Аюултай хог хаягдлыг төвлөрүүлэх байгууламжуудад дараах объектууд хамаарна.
Үүнд:

- Ашигласан тос төвлөрүүлэх байгууламж, талбай
- Ашигласан тосны шүүр, бохир алчуур, асгаралт шингэсэн материал цуглуулах талбай
- Бохир хөрс саармагжуулах талбай
- Ашигласан аккумулятор төвлөрүүлэх талбай

11.2 Ахуйн хог хаягдал

11.2.1 Уурхайн хог хаягдлын түр цэг тогтоолгож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх

Уурхай болон кемпийн хог хаягдал түр хуримтлуулах цэгүүдийг нэгтгэх, цөөн байршилд хог хаягдлын түр цэгийн захирамж гаргуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Тэдгээр цэгүүдэд хог хаягдал салхинд хийсэх, хур борооны усанд норохоос сэргийлж хашлага, хамгаалалт хийж тэмдэгжүүлнэ.

11.2.2 Хоол хүнсний хаягдал зайлуулж буй цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх

Кемпийн хог хаягдлын түр цэгт хүнсний хаягдал хуримтлагддаг тул ариутгал халдваргүйжүүлэлтийг тухай бүр хийж хөрсний биологийн бохирдол үүсэхээс сэргийлнэ.

11.2.3 Дахивар хаягдлыг ангилан ялгаж, хүлээн авах байгууллагад нийлүүлэх

Дахин ашиглах боломжтой буюу дахивар хаягдалд хаягдал төмөр, дугуй, модон эдлэлийн хаягдал, бүх төрлийн хаягдал цаас, шил, лааз гэх мэт зүйлсийг хамааруулан ойлгоно. Эдгээр хаягдлуудыг ангилал тус бүрээр нь хадгалж дахин ашиглана. Хэрэв төслийн хэмжээнд дахин ашиглах боломжгүй тохиолдолд дараагийн дахин ашиглах байгууллагад шилжүүлнэ.

Эргүүлэн ашиглах боломжтой хаягдлыг хүлээн авагч байгууллагад үнэгүй нийлүүлэх эсвэл тодорхой нөхцөлтэйгөөр тээврийн хөнгөлөлт үзүүлэх замаар нийслэл хот орчмын боловсруулах төвд хүргүүлэхэд нөхцөлийг хангаж ажиллана.

Цаашид хог хаягдлын гарцыг багасгахад зорилгоор нийлүүлэгч буцаан хүлээн авах бололцоог судлах ба эхний ээлжинд үйл ажиллагаанаас гарч буй 1-2 төрлийн хог хаягдлыг нийлүүлэгчид хүлээлгэн өгөх заалтыг гэрээнд тусгаж хэрэгжилтийг хангуулж ажиллана.

11.2.4 Хог хаягдлын урсгалыг хянах, бүртгэлжүүлэх

Хог хаягдлыг ангилал тус бүрээр бүртгэж төрийн захиргааны төв байгууллагад БОХ маягтын дагуу тайлагнаж ажиллана.

11.2.5 Шаардлагатай байршлуудад хог хаягдлын ангилан ялгах савыг шинээр байршуулах, шинэчлэх

Хог хаягдлын ангилан ялгалтын сайжруулах ажлын хүрээнд оффис, амрах байр, засварын шоп дахь хогийн савыг шинэчилнэ.

11.2.6 Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж тухай бүрт нь сумын төвлөрсөн хогийн цэгт буулган төлбөрийг төлж барагдуулах

ЭТТ ХК-ийн төслийн талбайн хэмжээнд үүссэн ахуйн хог хаягдлыг сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэх ба төлбөрийг тухай бүр төлнө.

11.2.7 Хог хаягдлын ландфиллын талбай байгуулах газрыг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газрын зөвшөөрлийг авах, зураг төслийг боловсруулж эхлэх

ЭТТ ХК-ийн төслийн талбайн хэмжээнд нэгдсэн хог хаягдлын цэг байгуулах ажлын хүрээнд 2-р зэрэглэлийн ландфиллын талбай байгуулахад шаардлагатай 10 га газрыг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж батлуулна. Газрын байршил тодорхой болсны үндсэн дээр зураг төсөл, ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг эхлүүлнэ.

11.2.8 Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу зогсоолын талбай байгуулах

Зөвшөөрөлгүй талбайд нүүрс тээврийн машинууд зогсох, хөрсөн бүрхэвчийг доройтуулах, хог хаягдал үүсгэх асуудлыг бууруулах үүднээс тодорхой байршлуудад шороон хөмсөг хийх, талбай байгуулах ажлыг хийнэ.

11.2.9 Нүүрс тээврийн замын хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах

Нүүрс тээвээрийн гэрээт байгууллагуудыг оролцуулан Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу тусгай зөвшөөрлийн талбай дахь хог хаягдлыг цэвэрлэж, тайлан мэдээг улирал бүр сумын Байгаль хамгаалагчид хүргүүлэн ажиллана.

12 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

12.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая.₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
11.1.1	Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	535398, 4839152; 538948, 4832820; 533688, 4831459; 539356, 4833238	Жилийн турш (3500 цаг/жил).	7 хоногт >60 цаг	11.4	34.3	Үйлдвэрийн тохиргоо	Агаарын тухай хууль, Ус, Цаг Уур, Орчны Хяналт Шинжилгээний Тухай Хууль, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Үндэсний Хөтөлбөр, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО- ГО07-X02
11.1.2	Цаг агаарын үзүүлэлт: салхины хурд, чиглэл агаарын хэм агаарын чийгшил агаарын даралт	538948, 4832820	Багажны худалдан авалт хийгдсэний дараа төлөвлөх		-	-	Багажгүй үеийн мэдээллийг ЦУОШГ- аас авах	
11.1.3	12.1.3 Хийн төлөвт бохирдуулагч болон хүлэмжийн хийн судалгаа /NO ₂ , SO ₂ , H ₂ S, CO, Formaldehyde/	SNO01-Бортээгийн зам дагуу SNO02-Уурхайн оффис гадна SNO03-ЦБУ карьер доод түвшин SNO04-ЦБУ нүүрсний агуулахын урд SNO05-2 уурхайн дунд SNO06-Цанхи хотхоны уурын зуух SNO07-Цанхи хотхоны авто машины граж SNO08-Уурхайн засварын шоп SNO09-Зүүн борлуулалтын хучлагын байр SNO10-Бортээг SNO11-Шинэ хотхоны уурын зуух	Намар, өвөл	1 удаа	95.1	95.1	-	Агаарын тухай хууль, Ус, Цаг Уур, Орчны Хяналт Шинжилгээний Тухай Хууль, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО- ГО07-X08

11.1.4	Гадаад орчны дуу шуугианы хэмжилт	4831852 535694 4829587 537406 4833759 531489 4839356 535517 4820645 532328 4832718 552557 4834704 536197	14 хоногт 1 удаа	180	-	-	-	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-Х02
11.1.5	Мониторингийн хөндлөнгийн хэмжилт хийлгэх, дүгнэлт гаргуулах	Уурхайн ус, агаарын мониторингийн цэгүүдэд	Жилд	1 удаа	21.7	21.7		ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо
11.1.6	Тоосонцорын агууламжийн хүнд металлын шинжилгээ	5 цэгт	Жилд	1 удаа	0.801	4.0		Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, Агаарын чанарын хяналт хийх горим. ЭТТ-СА-ГО41-БО-ГО07-Х02
11.1.7	Цацрагийн хяналт, шинжилгээ	5 цэгт	Жилд	1 удаа	0.23	1.16		

2018 оноос хойш “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн тоосонцорын хэмжилтийг хийж ирсэн. Уурхайн тоосонцорын мониторингийн тогтолцоог төрийн захиргааны байгууллага, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хөгжүүлэхийг зорьж байна. Тус зорилгод хүрэхийн тулд хэмжилтийн шууд аргачлалыг сонгож бүтэн хоногийн турш тасралтгүй явуулах, хэд хэдэн байршлууд дээр зэрэг хэмжилт явуулах, олон нийтийн оролцоог хамруулахыг эрмэлзэх зэрэг зоримог алхмуудыг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд бүс нутагт агаарын чанарын мониторингийн тогтолцоогоор тэргүүлж байна.

12.1.1 Гадаад орчны аэрозолын хэмжилт, тархалтын судалгаа

Аэрозолын хэмжилт буюу тоосонцорын хэмжилтийг гадаад агаарын тоосны түвшинг тодорхойлох үндсэн аргачлал болгон хэрэглэнэ. Аэрозолын хэмжилтийг шууд хэмжилтийн аргаар явуулах ба 2018 оноос хойш долоо хоногт 3 өдөр тус бүр 20-оос багагүй цагийн үргэлжлэлтэйгээр, 2021 оны 2-р хагас жилээс тоосонцорын хэмжилтийг 7 цэг дээр тасралтгүй зарчмаар буюу 7 хоног тутам цэг тус бүр дээр нийт 120 цаг/48 цаг болон 72 цагийг үргэлжлэлтэйгээр хийж ирсэн ба хэмжилтийн тайланг улирал бүр орон нутагт хүргүүлж байна.

2024 онд гэрээт туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран 4 цэг /535398 4839152, 538948 4832820, 533688 4831459, 539356 4833238/ дээр тус тус тоосонцорын хэмжилтийг явуулах ба 7 хоногт дунджаар 60-аас дээш цагийн хэмжилт хийж, нийт 3500 цаг/жил хүчин төгөлдөр хэмжилт хийж гүйцэтгэнэ. Хэмжилтийг хийж гүйцэтгэхдээ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Агаарын чанарын хяналт хийх горим”-ыг мөрдлөг болгоно.

Гадаад агаарын аэрозолын хэмжилтийн мэдээг тухайн орчны салхины хурд, агаарын чийгшил, хур тунадасны мэдээ, агаарын температур зэрэг цаг агаарын үзүүлэлтүүдтэй уялдуулан дата мэдээ боловсруулалт хийх ба 2018 оноос хойших хэмжилтийн мэдээтэй харьцуулсан тайлан боловсруулна.

12.1.2 Цаг агаарын үзүүлэлтийн хэмжилт, судалгаа

2024 онд агаарын даралт, салхины хурд, чиглэл, темдератур, хур тунадасны мэдээг хэмжих боломжтой цаг уурын автомат станц, гадаад агаарын нарийн ширхэглэгт тоосонцор PM2.5, том ширхэглэгт тоосонцор PM10 болон хийн төлөвт агаар бохирдуулагчууд болох азотын давхар исэл, угаарын хий зэрэг хийн төлөвт бохирдуулагчуудын хэмжилт хийх боломжтой агаарын чанарын суурин станцыг худалдан авахаар төлөвлөж байгаа ба цаг үеийн байдлаас шалтгаалан төхөөрөмжийн худалдан авалт хийгдэх явц хойшилсон тохиолдолд Цаг уур, орчны шинжилгээний газрын Архив мэдээллийн сангаас цаг уурын мэдээг авч дата мэдээ боловсруулалтанд ашиглана.

12.1.3 Хийн төлөвт бохирдуулагч болон хүлэмжийн хийн судалгаа

Агаарын найрлага дахь N₂, Ar, CO₂ хийнүүд байгалийн төлвөөсөө хэтэрсэн эсвэл өөр төрлийн бодисууд үүсгэж агаарын чанарын стандартаас давсан тохиолдолд агаарыг бохирдолтой гэж үздэг. Иймд антропоген хүчин зүйлээс үүдэн агаар дахь хийн төлвийн өөрчлөлтийг хянах, агаар бохирдуулагчийн үүсвэрийг тодорхойлох, стандартаас давсан үзүүлэлтийг илрүүлэх гол зорилгоор агаарын сорьц цуглуулан итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулан шинжлүүлнэ. Өмнөх жилүүдийн шинжилгээний хариунууд MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлтгүй тул хяналт тавих зорилгоор 2024 онд 1 удаагийн давтамжтай шинжлүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 7. Шинжилгээ хийлгэх үзүүлэлт.

№	Үзүүлэлт	Давтамж	Шинжилгээний стандарт
1	NO ₂	Жилд 1 удаа	MNS ISO 6768:2005
2	SO ₂	Жилд 1 удаа	ISO 6767:1990
3	H ₂ S	Жилд 1 удаа	MNS 3600:83
4	CO	Жилд 1 удаа	Тодорхойлогч төхөөрөмж
5	Formaldehyde	Жилд 1 удаа	NIOSH 3500

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийг бууруулах зорилго тавин ажиллаж байгаа бөгөөд уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын

хүрээнд хүлэмжийн хийг ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тооцоолох суурь судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна.

12.1.4 Дуу чимээний хяналт, тархалтын судалгаа

Дуу чимээ гэдэг нь орчинд тархаж байгаа механик хэлбэлзэх хөдөлгөөн бөгөөд түүний давтамжийг герц (Гц)-ээр, үзүүлэх хүчний түвшинг нь децибель (дБ)-ээр хэмждэг. Хүрээлэн буй орчинд үүсч буй дуу чимээний түвшин тодорхой стандарт хэмжээнээс давсан тохиолдолд хүний эрүүл мэндэд болон зэрлэг амьтдад сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг тул хяналт шинжилгээг явуулна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цанхийн баруун, зүүн уурхайд олборолтын үйл ажиллагаа эрчимтэй явагдаж хүнд даацын техник, технологи, өрөмдлөг тэсэлгээ, нүүрс тээврийн автомашинуудаас гарах дуу чимээг үүсгэгч гол цөм гэж үзэн түүнээс 2 км, 7 км-ын радиуст баффер татан, хэмжилт хийх 10 цэг тодорхойлсон. Хэмжилтийг Монгол улсын Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартыг мөрдлөг болгон ажиллана. PCE-EM882 багажийг ашиглан хэмжилт хийнэ.



Зураг № 2. Хяналтын цэгийн байршил.

12.1.5 Мониторингийн хөндлөнгийн хэмжилт хийлгэх, дүгнэлт гаргуулах

2010 оноос хойш уурхайн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг хянах, бууруулах зорилгоор ус, хөрс, агаарын чанарын хяналтыг тогтмол явуулж байгаа ба нийт хэмжилтийн дата мэдээллүүдийг баталгаажуулах, дүгнэлт гаргуулах, цаашид сайжруулах тал дээр зөвлөгөө мэдээлэл авах зорилгоор гадаад орчны агаар болон усан орчны хөндлөнгийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, зөвлөх үйлчилгээ авахаар төлөвлөж байна.

12.1.6 Тоосонцорын агууламжийн хүнд металлын шинжилгээ

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй агаар дахь тоосонцорын хэмжээ нь MNS 4585:2016 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлагын стандартаас 1-2 дахин давсан үзүүлэлттэй байгаа ба тус агаарт байгаа тоосонцор нь химийн маш олон төрлийн хортой бодисыг агуулж байдаг. Уурхайн хэмжээнд агаарын чанарын хяналтын цэг болон Цогтцэций сумын хяналтын цэгт тоосонцорт агуулагдаж буй хүнд металлыг шинжлүүлж хүрээлэн буй орчин болон хүний эрүүл мэндэд учруулж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох, хариу арга хэмжээ авч ажиллана.

12.1.7 Цацрагийн хяналт, шинжилгээ

Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторийн Цацрагийн хяналтын лабораторитай хамтран Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Тавантолгойн нүүрсний ордын хяналтын 5 цэгийг тодорхойлж Цанхийн уурхайн хүрээлэн буй орчны гамма цацрагийн тунгийн хэмжээ, орчны агаар дахь радоны концентрацийн хэмжилтийг 1 удаа хийлгэн хүрээлэн буй орчин болон хүний эрүүл мэндэд учрах аюулыг тодорхойлохоор төлөвлөж байна.

12.2 Усны хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая. ₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
12.2.1	ГДУ горимын судалгаа, усны түвшин, темп.	Уурхайн ашиглалтын 2 худаг, GW713, 21	Жил	6 цаг тутам		-	Solinst үйлдвэрийн гар түвшин хэмжигч багаж болон Levellogger автомат усны түвшин хэмжигч багаж ашиглан хэмжилтийг хийнэ. Гар түвшин хэмжилтийг сар бүр тогтсон өдөр хэмжинэ.	Байгаль орчны хяналт шинжилгээний журам – ЭТТ-СА-Ж06-БО-Ж02-Х02
12.2.2	Бага гүний усны түвшин	Гүн гашуу, Улаан овоо, Гурван толгой, Эргийн ус, Бунхант, Шорвогийн хүрэн толгой, Батболдын худаг		12 цаг тутам		-		
12.2.3	ГДУ геохимийн судалгаа: Макро, микро элемент	Уурхайн худаг болон Ахуйн хэрэглээний худаг /Нийт 17 худаг/ Нөлөөллийн бүсийн малчдын худаг /7 уст цэг/		Улиралд 1 удаа		66.6	-	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
12.2.4	Ахуйн усны эрүүл ахуйн үзүүлэлт	Ахуйн хэрэглээний худаг, ажилчдын хотхоны усны нөөцийн сав, цорго, усны машин /10 уст цэг/		Улиралд 1 удаа			-	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.
		Нөлөөллийн бүсийн малчдын худаг /7 уст цэг/		Хагас жилд 1 удаа			-	
12.2.5	Саарал усны хяналт шинжилгээ	Цэвэрлэх байгууламжийн саарал ус /4 цэвэрлэх байгууламж/		Улиралд 1 удаа			-	

Усны мониторингийн хөтөлбөрөөр үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаанаас газрын доорх усны горим, усны чанар, гидрогеохимийн найрлагад учруулж байгаа нөлөөлөл, өөрчлөлтийн хэмжээг тогтоохыг зорино. Газрын доорх усны мониторингоор уурхай ашиглалтын худгууд болон тусгай зөвшөөрлийн талбай дахь бага гүний уст худгуудын усны түвшиний өөрчлөлтийг тодорхойлох зорилготойгоор уст цэгүүдэд усны түвшин хэмжигч автологгер байршуулж жилийн турш тасралтгүй зарчмаар хяналт явуулна. Усны гидрогеохимийн шинжилгээгээр ионы балансад голлох үүрэг бүхий ионуудыг тодорхойлно.

12.2.1 Газар доорх усны горимын судалгаа

Газрын доорх усны горимын судалгаа нь уурхайд орж ирэх усны хэмжээг тодорхойлох загвар байгуулах, газар доорх усны шавхагдалтыг урьдчилан таамаглах боломж олгоно. 2019 оноос хойш бага гүний уст хэд хэдэн худагт усны түвшнийг автомат түвшин бичигч /автологгер/ ашиглан хийж ирсэн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дунд хугацааны стратегийн төлөвлөгөөний хүрээнд газар доорх усны тэжээгдэл, уст давхарга хоорондын гидравлик холбоог илрүүлэх зорилготой изотопын шинжилгээ, урсгалын хурдыг тодорхойлох, мөшигч⁵ ашиглах техникүүдийг ашиглана.

Уурхайн ашиглалтын аль болох олныг горимын хяналтанд хамруулахыг зорино. Одоо ашиглагдаж байгаа зарим худгуудад 32 мм-ийн хоолой байгаа ба цаашид байгуулагдах болон их засвар хийгдэх худгуудад 40 мм-ийн хоолой суурилуулан уст давхаргын түвшинд шүүр хийх байдлаар автологгеруудыг байршуулах боломжийг бүрдүүлнэ.

Одоогоор уурхайн хэмжээнд 2 ш хяналт /GW713, GW21/-ын цооног байгаа ба геофизикийн судалгаан дээр үндэслэж шинээр хяналтын цооног байгуулахаар төлөвлөж байна. Шинээр байгуулах хяналтын цооногууд үр дүнтэй, урт хугацаанд ашигтай байх шаардлагад нийцүүлэн ашиглалтын цооног, эсвэл шавхалтын цооногийг бараадуулан байгуулахыг зорино. Мөн хэд хэдэн уст давхаргын усыг холилдуулахгүйгээр тусад нь хэмжиж болохуйц тоноглолтойгоор хийгдэнэ.

12.2.2 Бага гүний уст цэгүүдийн судалгаа

2021 онд усны мониторинг хийхээр нөлөөллийн бүсийн бага гүний уст худгууд /Гүн гашуу, Улаан овоо, Гурван толгой, Эргийн ус, Бунхант, Шорвогийн хүрэн толгой /-ыг хулгайгаас сэргийлэх, аюулгүй байдлыг хангах худгийн байр барьж, 50Ø хоолой, дагалдах шүүр, бэхэлгээ, амсар, таг, худгийн ёроолын гүнээс хамаарсан урттай шууд дамжуулагч кабельтайгаар иж бүрэн тоноглон автологгер суурьлуулсан. Тус онд уурхайгаас баруун урд зүгт байрлах нөлөөллийн бүсийн малчин айл Батболдын худагт автомат логгер суурилах, өмнөх жилүүдэд суурилуулсан логгеруудын хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай засвар үйлчилгээг хийхээр төлөвлөж байна.

Хэмжилтийн нэгдмэл байдал, уялдаа, өгөгдлийн боловсруулалт хийх боломжийг хангах үүднээс өмнөх оны хэмжилттэй адил байхаар буюу автологгерийн бичилтийн давтамжийг 12 цаг /12:00, 00:00 гм/- ийн зайтайгаар програмчилна. Хэмжилтийн дата мэдээг авахдаа тухайн ойр орчмын малчин иргэдийг оролцуулан худгийн усны түвшиний мэдээлэл өгч хамтын оролцоот мониторингийг хэрэгжүүлэн ажиллахыг эрмэлзэнэ.

12.2.3 Усны геохимийн үзүүлэлтийн тодорхойлолт

Ус чулуулгийн харилцан үйлчлэлийг судлах, техноген үйлчлэлийн цар хүрээ, нөлөөллийн хэмжээг тодорхойлох зорилгоор нийт уст цэгүүдэд усны гидрогеохимийг судлана. Ингэхдээ эдийн засгийн хэмнэлттэй байх зарчмаар буюу хэт ойр ойрхон давтагдсан утгатай болон шаардлагагүй үзүүлэлтүүдийг шинжлүүлэхээс зайлсхийнэ. Хамгийн гол нь усны химийн үзүүлэлтийг тодорхойлох аргачлалын үнэн зөв байдал, нарийвчлалыг шалгахад анхаарал хандуулна. Зарим аргачлалаар бичил элементүүдийг

⁵ Tracer

илрүүлэх хязгаар нь хэт доогуур байдаг. Ийм аргачлалаар бичил элементийг ойр ойрхон давтан шинжлүүлэхгүй байх зэргээр дэмий зардал гаргахгүй байх, хэмнэлтийн зардлаар ион хроматограф (DX-120) зэрэг илүү нарийвчлалтай (± 0.01 мг л⁻¹) аргачлалаар үзүүлэлтийг тодорхойлуулахад төвлөрч ажиллана.

12.2.4 Усны эрүүл ахуйн үзүүлэлт, бохирдлын судалгаа

Худгийн ус эрүүл ахуйн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор нийт ундны усны худаг, бага гүний уст худгууд болон ажилчдын эрүүл ахуйн шаардлагыг хангах үүднээс хотхоны усны нөөцний савнаас дээж авч микробиологийн шинжилгээ хийлгэнэ.

12.2.5 Саарал усны хяналт шинжилгээ

Ажилчдын хотхоны цэвэрлэх байгууламжууд болох Грийн центр, Цанхи хотхон, Эрдэнэс хотхон, уурхайн оффисын бохир усны цэвэрлэх байгууламжийн гаралтын усны стандарт шаардлагын нийцлийг шалгах зорилгоор MNS 4943:2015 стандартын дагуу гол үзүүлэлтүүдийг (Жинлэгдэх бодис, ХХХ, БХХ, ПИЧ, Органик бодис /нийт азот/, Эрдэс бодис /Фосфор/) шинжлүүлнэ.

Цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэршүүлсэн бохир ус нь хүрээлэн байгаа орчин Хаягдал усны чанарын MNS4943:2015 стандартын шаардлага хангасан тохиолдолд уурхайн зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглахаар төлөвлөж байна.

12.3 Хөрс, ургамлан бүрхэвчийн мониторинг

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая.₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
12.3.1	Хөрсний чанар-Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Point-05- Мод үржүүлгийн талбай Point-06-Нөхөн сэргээлтийн талбай SCP008-Уурхайн засварын шоп урд SCP012- ЦЗУ SCP015-Борлуулалтын талбай SCP002- Хяналтын цэг SCP014- Хяналтын цэг DF30- Хяналтын цэг	Жил	2 удаа	Гүйцэтгэл	17.2	Бор тээгийн тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа эхлэхэд нэмж хяналтын цэг тодорхойлж хөрсний дээж авна.	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990
12.3.2	Хөрсний чанар-нянгийн шинжилгээ	Эрдэнэс Тавантолгой ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын цэвэрлэх байгууламжийн орчим		2 удаа			>5	
12.3.3	Хөрсний чанар-Хүнд металлын шинжилгээ	ШТС болон хаягдал тосны талбай орчим		2 удаа			>5	
12.3.4	Шимт хөрсний овоолгын чанарын шинжилгээ	Удаан хугацаанд хадгалсан овоолгууд		2 удаа			Хөрсний шим тэжээлийн бодис, ялзмаг, бохирдлын шинжилгээ хийлгэх.	

12.3.5	Тусгай зөвшөөрлийн талбайнд ургамлын мониторинг хийх	4 трансектийн дагуу 24 цэгт		2 удаа		-	Нөлөөллийн бүсэд ургадаг бэлчээрийн ургамлын геоботоникийн бичиглэл хийх	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хууль, ЭТТ ХК-ийн дотоод журмууд Өнгөн хөрстэй ажиллах журам, Ховор, нэн ховор ургамлыг хамгаалах журмууд
--------	--	-----------------------------	--	--------	--	---	--	---

12.3.1 Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд

Хөрсний үндсэн хими, физик шинж чанарыг тодорхойлох судалгааны хүрээнд хяналтын цэгт хөрсний үе давхаргын ил гарсан 30-40 см гүнтэй хөрсний зүсэлт-ухалт гүйцэтгэн өнгө болон бүтцээр ялгаатай үе давхаргуудаас лабораторын задлан шинжилгээнд зориулан дээжийг бэлтгэнэ.

Хяналтын үр дүнд техноген нөлөөг тогтооход ашиглагдах хөрс бохирдуулагчийн хэмжээний мэдээг цуглуулахаас гадна шимт хөрс, үрсэлгээний талбай зэрэг нөхөн сэргээлтийн холбогдолтой байршлуудаас авсан дээжийг шинжилгээнд хамруулна.

12.3.2 Хөрсний чанар- нянгийн шинжилгээ

ЭТТ ХК-ийн Цанхи хотхон, Эрдэнэс хотхон, Грийн центр болон уурхайн оффисын цэвэрлэх байгууламж, гэрээт байгууллагуудын ажилчдын хотхоны цэвэрлэх байгууламжуудаас хөрсөн орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хянах зорилгоор нянгийн шинжилгээг хийлгэнэ. Шинжилгээгээр нянгийн тоо, ГБЭТ, Перфрингенс зэрэг үзүүлэлтүүдийг шинжлүүлнэ.

12.3.3 Хөрсний чанар- Хүнд металлын шинжилгээ


Хүнд металлын шинжилгээг дугтуйн аргаар буюу 1м² талбай сонгон 4-н захын цэг болон төвийн хэсгээс 50гр орчим шороо цуглуулан холих маягаар дээж авна. Уурхайн гэрээт байгууллалагуудын засварын цэгүүдийн орчим болон ШТС-н орчмоос дээжийг авч 2-с доошгүй удаа шинжлүүлнэ. Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд хар тугалга, кадми, никель, хром, зэс, цайр зэрэг үзүүлэлтүүдээс гадна нефтийн бохирдол болон хүчиллэг урсацын шинжилгээг хийлгэнэ.

12.3.4 Шимт хөрсний овоолгын чанарын шинжилгээ

Цанхийн баруун, зүүн уурхайн шимт хөрсний удаан хадгалагдах овоолгуудын үржил шим, чанарын элементүүдийн алдагдал, хөрс сайжуурлалтын ажлын үр дүнг хянах зорилготой. Хөрсний хими, физик шинж чанарын үзүүлэлтээр ялзмаг, рН, карбонат, шингээгдсэн Са, Mg, хөдөлгөөнт P2O5, механик бүрэлдэхүүн, цахилгаан дамжуулах чадвар, хялбар уусах давсны агуумж зэрэг үзүүлэлтийг шинжлүүлнэ.

12.3.5 Бэлчээрийн ургамлын мониторинг

Анх 2014 оноос хяналтын цэг байгуулан урт хугацааны давтамжтайгаар Тавантолгой ордын тусгай зөвшөөрлийн талбайнд 3 трансекцийн 19 цэгт 2021 оны хүртэл хийсэн. Уурхай нь овоолготой ойр цэгүүдийн ургамлын төрөл, зүйлийн тоо багасаж 2023-2024 он гэхэд ахилтанд өртөхөөр байгаа учир 2022 онд 1 трансекцийн 4 цэгийг нэмсэн.



Зураг № 3. Тусгай зөвшөөрлийн талбайн ургамлын мониторинг хийх байршил.

2024 оны 6-р болон 8-р саруудад нийт 4 трансектийн дагуу 24 цэгт ургамалжилын тархацын төрх байдал (сөөгжилт, чулуужилт, доройтол)-ын ургамлын болон хагд, элс, хайрга чулууны бүрхэц, мал бэлчээрлэлт, уурхайн нөлөө зэргийг геоботаникийн бичиглэл хийж судална. Геоботаникийн бичиглэлээр ургамал бүрийн өндөр /ургал ба үржлийн найлзуур/, тусгагийн бүрхэц, арви, үзэгдэлзүйн үе шат, хөрсны бүрхэц зэргийг бичиж тэмдэглэнэ. Мөн өмнө жилүүдэд хийгдсэн ургамлын мониторингийг тухайн он мониторингийн дататай хариуцлалт хийх, цаг агаарын мэдээ, тухай газрын малын тоо зэргийг харьцуулан график гарна.

Хүснэгт 8. Хяналтын цэгийн координат.

№	X	Y	№	X	Y
1	531203.4	4829034.7	13	554999.8	4825238.6
2	527832.2	4826636.0	14	525414.7	4839180.4
3	522337.7	4822480.6	15	533063.7	4833115.9
4	541092.0	4832133.0	16	530841.9	4834099.3
5	543773.1	4832597.4	17	527600.2	4835683.7
6	547502.1	4833406.4	18	533546.7	4831069.7
7	551059.0	4834932.0	19	532835.8	4830282.6
8	554850.1	4836658.9	20	528920.9	4827599.1
9	557591.0	4839495.7	21	525640	4824898.6
10	540876.4	4829635.8	22	542226.9	4832278.9
11	544629.0	4829551.8	23	542028.2	4829315.9
12	551891.7	4828058.4	24	547863.4	4829543.2

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцах ажилтан	Тайлбар
			1-улирал	2-улирал	3-улирал	4-р улирал		
13.1	ЭТТ ХК БОМ болон Гэрээтийн БОМ сургалт, зааварчилгаа хүргэх	-	Мониторингийн дата мэдээлэл боловсруулах SPSS	Excel програмын чадавхыг сайжруулах	Байгаль орчны хууль, эрхзүйн сургалт	DustTrak төхөөрөмж ашиглах чадварыг сайжруулах	БОМ	Байгаль орчны мэргэжилтнүүдийг чадавхижуулах
13.2	Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг зохион байгуулах.		БОМТ-г батлах, гэрээний хэрэгжилтийг хангуулах	Хог хаягдлын байгууламжуудын стандарт шаардлагыг нийцүүлэх	Зөрчил, үл нийцлийг арилгуулах	БОМТ-н хэрэгжилтийг хангуулах	БОУБ-ын хэлтэс	Хяналтын системийг сайжруулах
13.3	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр сумын төвийн зорилтот 30 айл өрхөд эко жорлон байрлуулах /хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан/	100.0		15 өрх	15 өрх		Орон нутаг хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны мэргэжилтэн	
13.4	Сумын төвийн 2-с доошгүй худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хашаажуулах	2.1			2 худгийн хамгаалалтын хашаа		Орон нутаг хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны мэргэжилтэн	

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцах ажилтан	Тайлбар
			1-улирал	2-улирал	3-улирал	4-р улирал		
13.5	Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр малчдыг туршлага судлуулах			3 малчин	3 малчин		Орон нутаг хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны мэргэжилтэн	
13.6	Цагаан-Овоо багийн малчдын хоршооллыг дэмжиж ажиллах	65.0		Санамж бичиг байгуулах			Орон нутаг хариуцсан мэргэжилтэн	
13.7	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах	0.32	Дэлхийн зэрлэг амьтан, ургамал хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх өдөр, Дэлхийн усны өдөр	Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр			Байгаль орчны мэргэжилтэн	
13.8	БОМТ-ний төлөвлөлтийг сайжруулах, тайлангийн бичилтийг сайжруулж тоо баримт, үндэслэл, баримт нотолгоог хавсралтаар бүрэн оруулах	-	БОМТ төлөвлөгөө боловсруулах, хянуулах, батлуулах			БОМТ хэрэгжилтийн тайлан боловсруулах, батлуулах	Байгаль орчны мэргэжилтэн	

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцах ажилтан	Тайлбар
			1-улирал	2-улирал	3-улирал	4-р улирал		
13.9	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгаас хуваарилсан 3.5 сая модны төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Тэрбум мод хөтөлбөрийн төсвөөр	Төлөвлөгөө боловсруулах		Төлөвлөгөө батлуулах		Тэрбум мод төслийн нэгж	
13.10	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон суманд 20га-с багагүй талбайд загаар ойжуулалт хийх			+	+	+		
13.11	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Цогтцэций, Цагаан-Овоо, Манлай суманд байгуулах ойн зурвасын ажлыг эхлүүлэх			+	+	+		
13.12	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Модлог ургамлын тарьц, суулгац үржүүлэх		20000ш				Байгаль орчны мэргэжилтэн	

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцах ажилтан	Тайлбар
			1-улирал	2-улирал	3-улирал	4-р улирал		
13.13	Галба-Өөш Долоодын говийн сав газрын зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны төсөв			+		БОУБХ-н дарга, ахлах мэргэжилтэн	

14 НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цогтцэций сумын Цагаан-Овоо, Билгэх, Сийрст багийн иргэдэд БОМТ-нд тусгагдсан малчид болон олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжуудыг тухай бүр танилцуулж, хэрэгжсэний дараа ажлын тайлан, мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж ажиллана.

Бүлэг	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Нийт зардал, сая ₮	Хариуцах ажилтан	Зохион байгуулах газар
14.1	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах	Компанийн албан ёсны вэб хуудас	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн.	II улиралд	Зардалгүй	БОУБХ	Цогтцэций сум
14.3	Цогтцэций сумын Цагаан-Овоо, Билгэх, Сийрст багийн иргэд	Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	БОМТ болон БОМТ-ний биелэлтийг танилцуулах.	Жилд 2 удаа	Үйл ажиллагааны зардал		

15 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.

№	БОМТ ангилал	Төсөв, мян.төг₮
1	Нөлөөлөллийг бууруулах үйл ажиллагаа	132,700.00
2	Зохион байгуулалтын төлөвлөгөө	167,449.00
3	ОХШХөтөлбөр	240,416.33
4	Хог хаягдлын менежмент	159,558.81
5	Соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	233,165.83
7	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	365,000.00
8	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17,377.36
Нийт		1,тө

16 ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР

Бүлэг	Арга хэмжээ	Хамрах хүрээ, давтамж	Биелэлийн шалгуур	Эзлэх жин
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				20
5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				4
5.1.1	Тоос бууруулах бодисыг технологийн замд ашиглана.	Уурхайн технологийн зам	Цанхийн уурхайнуудын технологийн замын 5 км замд бодисыг ашигласан байна.	0.5
5.1.2	Уурхайн ашиглалтын замыг сайжруулах: материал, дэвсгэлт хийх	Уурхайн технологийн зам, талбай	Цанхийн уурхайнуудын технологийн замын 10-аас багагүй км замд сайжруулах дэвсгэлт хийж сайжруулсан байна.	0.5
5.1.3	Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах	Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбай	Уурхайн хэмжээнд 5-аас доошгүй усалгааны машиныг жилийн турш тогтмол усалгаанд ашигласан байна.	0.5
5.1.4	Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих	Уурхайн технологийн зам	Сар бүр уурхайн хөдөлгөөнт техникүүдэд хяналт шалгалтыг тогтмол хийсэн байна.	0.4
5.1.5	Кемп хоорондын зам болон ачаа тээврийн сайжруулсан шороон замын засвар үйлчилгээ, арчилгааны хуваарь гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	Кемп хоорондын шороон зам болон ачаа тээврийн сайжруулсан шороон зам	Сайжруулсан шороон замын засвар үйлчилгээний хуваарийг бүх гэрээт компаниудыг оролцуулан боловсруулж батлуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан байна.	0.5
5.1.6	Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Нүүрс ачилтын талбай	Нүүрс ачуулан гарч буй бүх техникт хучлагыг бүрэн хийлгэсний дараагаар ачилтаас гаргах үйл ажиллагаанд байнгын хяналт хийсэн байна.	0.2
5.1.7	Нүүрс ачилтын талбайд усалгаа хийх	НАБТ	Нүүрс ачилтын талбайд 2-оос доошгүй усны машин ажиллуулж, усалгааг тогтмол хийнэ.	0.4
5.1.8	Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгсэл	Үйлдвэрлэл техникийн газрын Засвар механикийн хэлтэстэй хамтран уурхайн ажилд ашиглагдаж буй автомашинуудыг тээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулах ажиллана.	0.5
5.1.9	Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих	Цанхи хотхон болон Грийн центрийн уурын зуух	Цанхи хотхон болон Грийн центрийн уурын зуухнаас ялгарах утааны шинжилгээний хэмжилтийг итгэмжилсэн лабораторид шинжлүүлж стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллана.	0.5
5.2 Гадаргын болон газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				4
5.2.1	Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.	Эзэмшлийн худгууд	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ын уурхайн эзэмшлийн 18 худагт сар бүр тогтмол үзлэг шалгалтыг хийнэ.	0.5
5.2.2	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авах, ус ашиглах гэрээ байгуулна.	Уурхайн хэмжээнд	Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж дүгнэлтэнд заагдсаны дагуу холбогдох гэрээг байгуулж төлбөрийг	1

5.2.3	Усны нөөц ашигласны төлбөр төлөх, ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах	Уурхайн хэмжээнд	сар бүрийн тоолуурын заалтыг сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулж төлбөрийг тогтмол хугацаанд нь төлсөн байна.	0.5
5.2.4	Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх	Цэвэрлэх байгууламжууд	Сав газрын захиргаанаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авч, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулан улирал бүрийн дүгнэлтийг үндэслэн зохих төлбөрийг улирал бүр төлнө.	0.5
5.2.5	Замын тоосжилт бууруулахад ашиглах гадаргын болон гүний усны харьцааг 0.32-аас бага түвшинд байлгах.	ЭТТ, гэрээт компаниуд	Гадаргын усыг зам талбайн тоосжилт бууруулах усалгаанд ашиглах, зорилтод түвшинд байлгана.	0.5
5.2.6	Хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх, стандарт шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглах	ЭТТ, гэрээт компаниуд	Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх түүнд хяналт тавих, стандарт шаардлагад шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглана	0.5
5.2.7	Уурхайн газар доорхи усны нөөц, чанарт байнгын хяналт тавих	GW713, №21, 2	Уурхайн газар доорхи усны мониторингийн цооногуудад түвшний хэмжилт хийх, усны чанарыг лабораторид шинжлүүлнэ.	0.5
5.2.8	Булгийн эхийг сэргээх, хашиж хамгаалах /Мухар гашуу булаг/	ЭТТ, гэрээт компаниуд	Цогтцэций сумын нутагт байрлах Мухар гашуу булгийн эхийг сэргээх, хашиж, хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, орон нутагт хүлээлгэн өгнө.	0.5
5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				4
5.3.1	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах	Уурхайн хэмжээнд	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимыг хангуулж байгаль орчны чиглэлийн дотоодын журам, горимуудыг мөрдөнө.	0.5
5.3.2	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарих	Уурхайн хэмжээнд	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах.	1
5.3.3	Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Тусгай зөвшөөрлийн талбай хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-д тавих хяналтыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн томилогдсон ажлын хэсэг болон орон нутагтай хамтран хэрэгжүүлнэ.	0.5
5.3.4	Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Уурхайн дотоод зам талбайн ашиглалтын байдалд сар бүр тогтмол хуналтыг хийж мөрдүүлнэ.	0.5
5.3.5	Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах	Уурхайн хэмжээнд	Шимт хөрс байрлуулсан талбай дүүрсэн тохиолдолд Маркшейдэр инженерийн хэмжилтийн дүн болон /ЭТТ-СА-Ж41-БО-Ж09-Х03/ “Өнгөн хөрстэй ажиллах журам”-ыг баримтлан акт үйлдэн хаана	1
5.3.6	Уурхайн хэмжээнд шимт хөрсний судалгаа хийж зөөгдөөгүй үлдсэн шимт хөрсийг зохих овоолгод байршуулах	Уурхайн хэмжээнд	Өнгөн хөрстэй ажиллах журам /ЭТТ-СА-Ж41-БО-Ж09-Х03/, Газар хөндөх журам /ЭТТ-СА-Ж11-БО-Ж07-Х03/-ын батлагдсан маягтын дагуу олгож, олгосон зөвшөөрлийн дагуу	0.5

			бүртгэлийг хийж, хяналт тавьж ажиллана.	
5.4 Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				2
5.4.1	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах.	Тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээнд жилийн турш	Газар хөндөх зөвшөөрлийг баталсан журам, зохион байгуулалтын дагуу хэрэгжүүлэн, газар хөндөх зөвшөөрлийн үйл явцад сайжруулалт хийж газрын хэмжээг GIS систем болон нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.	1
5.4.2	Тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх, хяналт хийх.	Тусгай зөвшөөрөлтэй талбайд сар бүр тогтмол	Холбогдох зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахгүй байлгах үүднээс Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам /ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х01/-ын дагуу тогтмол хяналт хийнэ.	1
5.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				2
5.5.1	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгах	Тухайн жилийн ахилтын хүрээ	Уурхайн ахилтад өртөх талбайд ховор, нэн ховор ургамлын тархалтын судалгааг хийж тухайн талбайд бүртгэгдсэн ургамлыг Байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг нэмэгдүүлэх зорилгоор мод үржүүлгийн талбайд шилжүүлэн суулгана.	1
5.5.2	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Ажилтнуудад	Байгалийн ургамлын тухай хууль, Зөрчлийн тухай хуульд ховор, нэн ховор ургамлыг зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн тохиолдолд хүлээх хариуцлагын тухай сургалтын материал боловсруулж сургалт орно.	1
5.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				4
5.6.1	Өвөлжилт хүрдэрсэн үеп биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх.	Цогтцэций сум	Биотехникийн арга хэмжээг орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан албан хаагч нартай хамтран авч хэрэгжүүлнэ.	1
5.6.2	Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамаар хяналт хийх, шаардлагатай тохиолдолд нэмж шувуу үргээгч байршуулах	Уурхайн хэмжээнд	Цахилгааны шугам дагуу шувууны өртөлтийн судалгааг хийж, гарсан үр дүнд үндэслэн шаардлагатай газруудад стандарт шаардлагад нийцсэн шувуу үргээгч байрлуулна.	1
5.6.3	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Төслийн хэмжээнд	Төслийн хэмжээнд гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран хууль бус хулгайн антай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон хориотой ан амьтны талаарх сургалтыг зохион байгуулна.	1
5.6.4	Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулахад орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	Орон нутаг	Цогтцэций сумын байгаль хамгаалагчтай хамтран хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулах ажилд оролцоно.	1
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө				30
6.1 Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө				20

6.1.1	Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	Тусгай зөвшөөрлийн талбайд	Цанхийн зүүн болон, баруун уурхайн талбайн хэмжээнд үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж ашиглагдахгүй болсон газрын судалгааг, гэрээт туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран гаргана. 3-аас багагүй га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.	20
6.2 Биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө				15
6.2.1	Үрийн нөөц бүрдүүлэх	ЭТТ, гэрээт компаниуд	Говийн бүсэд ургадаг модлог ургамал болон нутгийн унаган ургамлын үрийг 10 кг-аас багагүйг түүж нөөц бүрдүүлнэ.	5
6.2.2	Модлог ургамлын мөчир бэлтгэх,	ЭТТ	Сэжмээр ургах боломж бүхий модлог ургамлын мөчир бэлтгэх ажлын хүрээнд 5000-10000 ширхэг мөчир бэлтгэж хадгална.	5
6.2.3	Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бордоог нөхөн сэргээлтэд ашиглах	Үрсэлгээний талбай	Цэцэрлэгжүүлэлтийн үлдэгдэлд / хугарсан мөчир, хатсан навч, холтос/, хог ургамал гэх мэтийг ашиглан 1 тн-оос багагүй био компост бордоог гарган авч мод үржүүлэгт ашиглана.	5
6.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн				15
6.3.1	Өмнөговь аймгаас хуваарилсан 3.5 сая модны төлөвлөгөө боловсруулж, батлуулах.	Өмнөговь аймгийн хэмжээнд	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймаас хуваарилсан 3.5 сая модны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, хэрэгжүүлж эхлүүлнэ.	5
6.3.2	Төлөвлөсөн талбайд Заг мод тарих.	Өмнөговь аймаг, Номгон сум	Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт 10 га-аас багагүй талбайд 100 000 ширхэг загийг тарьцаар тарьж ургуулна.	5
6.3.3	Модлог ургамлын тарьц, суулгац үржүүлэх.	“Эрдэнэс” агропарк 10 га талбай	“Эрдэнэс” агропаркийн мод үржүүлгийн 10 га талбай дээр 20000 доошгүй тарьц суулгацыг тарина.	5
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө				10
7.1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах	Дүйцүүлэн хамгаалах газар нутагт	Дүйцүүлэн хамгаалан талбайд цаашид хэрэгжүүлж ажиллах дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдлөг болгон ажиллана.	1
7.2	2023 онд хийгдсэн дүйцүүлэн хамгаалах ажлын тайланг малчдад танилцуулах		Дүйцүүлэн хамгаалах талбайн байршилд өмнө жил хийгдсэн ажлын талаар тухайн газрын ойр орчимд суурьшсан малчдад тайлагнах ажлыг зохион байгуулна.	1
7.3	Хулгайн ангийн мэдээллийг хүлээж авах 24 цагийн утсыг ажиллуулах, экологийн цагдаад мэдээллэх		Зэрлэг ан амьтдыг хамгаалах ажлын хүрээнд сум орон нутгийн экологийн цагдаагийн албатай хамтран ажиллана. Амьтдыг хамгаалах зорилгоор 24 цагийн мэдээллийн утасыг ажиллуулж экологийн цагдаад мэдээллэнэ.	1
7.4	Бэлчээр усжуулах худаг гаргах		Уст цэгийг нэмэгдүүлэх, бэлчээр усжуулах зорилгоор 1ш худаг гаргаж ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн.	1
7.5	Бэлчээр хашиж, ургамлын нөмрөгийг сайжруулах		Дүйцүүлэн хамгаалах талбайд ургамлан нөмрөгийг сайжруулах зорилгоор 2 га газрыг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.	1
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө				5
	Цагаан овоо багийн иргэдтэй гэрээ байгуулах, нөхөн олговор олгох	Тосгоны иргэд	Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд хамтран ажиллаж, 40 иргэнд нөхөн олговор олгосон байна.	5

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө				5
9.1	Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл мэдээлэх.	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээгээр	Соёлын дурсгалт зүйл олдсон тохиолдолд олборлох ажлаа зогсоож энэ тухай, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.	5
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө				10
10.1 Нүүрс устөрөгч, Химийн бодис хяналтгүйгээгээр асгарах				2
10.1.1	ХАЛМ-ийг химийн бодис ашигладаг ажлын байруудад байрлуулах, сургалт зохион байгуулах.	Уурхайн хэмжээнд	>500 хүнд сургалт зохион байгуулна.	1
10.1.2	Асгаралтыг бүртгэлжүүлж тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах	Уурхайн хэмжээнд	Асгаралт гарсан тохиолдол бүрийг бүртгэлжүүлж, хариу арга хэмжээг авч, бохирдсон хөрсийг тусгай талбайд байршуулна.	1
10.2 Байгалийн аюул, гамшигт нөхцөл байдал				4
10.2.1	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Уурхайн хэмжээнд	Төлөвлөгөөг холбогдох байгууллагуудын удирдлагаар батлуулна.	1
10.2.2	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	Уурхайн хэмжээнд	Төслийн хэмжээнд гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнууд />800/-д танилцуулна.	2
10.2.3	Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	Уурхай, хотхоны хэмжээнд	Уурхай болон ажилтнуудын хотхоныг үерийн уснаас хамгаалах ус зайлуулах шугам, хамгаалах даланг шаардлагатай газруудад хийнэ.	1
10.3 Гал түймрийн аюул, эрсдэл				4
10.3.1	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх.	Уурхайн хэмжээнд	“Галын аюулгүй байдлын журам”-ыг мөрдөж ажиллана.	1
10.3.2	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих.	Уурхайн хэмжээнд	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан эсэхэд хяналт тавина.	1.5
10.3.3	Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг, шуудууг татах, сэргээх	ШТС-ын талбай	Уурхайд байрлах зөөврийн ШТС-ыг хамгаалсан үерийн суваг шуудууг сэргээн засварлах, ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх, ажлын байрны үзлэг хийж зөрчил дутагдлыг арилгах, тэмдэг тэмдэглэгээг сэргээх ажлуудыг тогтмол хийнэ.	1.5
11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө				5
11.1 Аюултай хог хаягдал				2
11.1.1	Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу байгуулах	Засварын талбай	Хаягдал тос цуглуулах талбайг нэвчилтээс сэргийлж, бетон суурьтай болгоно.	1
11.1.2	Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх.	ЭТТ болон гэрээт байгууллагууд	Тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан, нийлүүлнэ.	0.5

11.1.3	Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын талбайн стандартыг хангуулахад хяналт тавих	Цанхийн баруун, зүүн уурхайн гэрээт байгууллагууд	Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын талбайд Ажлын байрны үзлэгийг тогтмол хийнэ.	0.5
11.2 Ахуйн хог хаягдал				3
11.2.1	Уурхайн хог хаягдлын түр цэг тогтоолгож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Уурхайн хэмжээнд	Хог хаягдлын түр цэгийн байршлыг тогтоож, захирамж гаргуулна.	0.2
11.2.2	Хоол хүнсний хаягдал зайлуулж буй цэгт ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийх	Ажилчдын хотхон	Ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийнэ.	0.2
11.2.3	Дахивар хаягдлыг ангилан ялгаж, хүлээн авах байгууллагад нийлүүлэх	ЭТТ болон бүх гэрээт	Дахивар хог хаягдал авах байгууллагатай гэрээ байгуулж, нийлүүлнэ.	0.2
11.2.4	Хог хаягдлыг урсгалыг хянах бүртгэлжүүлэх	Төслийн хэмжээнд	Хог хаягдлын журмын хүрээнд хог хаягдлыг бүртгэлжүүлж, тайланд оруулна.	0.2
11.2.5	Шаардлагатай байршлуудад хог хаягдлын ангилан ялгах савыг шинээр байршуулах, шинэчлэх	Уурхай, захиргааны байр	Хогийн сав нэмж байршуулна.	0.2
11.2.6	Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж тухай бүрт нь сумын төвлөрсөн хогийн цэгт буулган төлбөрийг төлж барагдуулах	ЭТТ ХК-ийн гэрээт болон туслан гүйцэтгэгч компани	Хог хаягдлын журмын хүрээнд хог хаягдлыг бүртгэлжүүлж, сумын төвлөрсөн хогийн цэгт буулган төлбөрийг төлж барагдуулна.	0.3
11.2.7	Хог хаягдлын ландфиллын талбай байгуулах газрыг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газрын зөвшөөрлийг авах, зураг төслийг боловсруулж эхлэх	Төслийн хэмжээнд	Хог хаягдлын ландфиллын талбай байгуулах газрыг 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газрын зөвшөөрлийг авах, зураг төслийг боловсруулж эхлүүлнэ..	1
11.2.8	Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу зогсоолын талбай байгуулах	Тээврийн зам дагуу	Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу зогсоолын талбай байгуулна.	0.5
11.2.9	Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто замын 0-8 дахь км-ын дагуу талбайн үзлэгийг тогтмол зохион байгуулж, хяналт тавих	Тээврийн зам	Тээврийн албатай хамтран зохион байгуулна.	0.2
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр				5
12.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ				2
12.1.1	Агаар дахь тоосонцорын хэмжилт	4-өөс доошгүй цэгт	Жилийн турш 3500 цагийн хүчин төгөлдөр хэмжилтийг хийсэн байна.	0.4
12.1.2	Цаг уурын үзүүлэлтийн хэмжилт	1 цэгт	Багадаа 3 үзүүлэлтээр жилийн турш хэмжилт хийсэн байна.	0.2
12.1.3	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ /NO2, SO2, H2S, CO, Formaldehyde/	10 цэгт	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.	0.4
12.1.4	Гадаад орчны дуу шуугианы хэмжилт	7 цэгт	14 хоногт 1 удаа жилийн турш хийж гүйцэтгэсэн байна.	0.2
12.1.5	Мониторингийн хөндлөнгийн хэмжилт хийлгэх, дүгнэлт гаргуулах	Уурхайн ус, агаарын мониторингийн цэгүүдэд	Мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт тайланг авсан байна.	0.3
12.1.6	Тоосонцорын агууламжийн хүнд металлын шинжилгээ	5 цэгт	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн байна.	0.2
12.1.7	Цацрагийн хяналт, шинжилгээ	5 цэгт	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн байна.	0.3

12.2 Усны хяналт шинжилгээ				2
12.2.1	Газрын доорхи усны гормиын судалгаа	6 цаг тутам	Solinst үйлдвэрийн гар түвшин хэмжигч багаж болон Levellogger автомат усны түвшин хэмжигч багаж ашиглан хэмжилтийг хийнэ. Гар түвшин хэмжилтийг сар бүр тогтсон өдөр хэмжинэ.	0.4
12.2.2	Бага гүний усны түвшин хэмжилт	12 цаг тутам		0.4
12.2.3	Газрын доорхи усны геохимийн судалгаа	Улиралд 1 удаа		0.4
12.2.4	Ахуйн усны эрүүл ахуйн үзүүлэлтийн судалгаа			0.4
12.2.5	Саарал усны хяналт шинжилгээ	Улиралд 1 удаа		0.4
12.3 Хөрс, ургамлан бүрхэвчийн мониторинг				1
12.3.1	Хөрсний чанар - Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Жилд 2 удаа	Мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн байна.	0.2
12.3.2	Хөрсний чанар - нянгийн шинжилгээ			0.2
12.3.3	Хөрсний чанар - Хүнд металлын шинжилгээ			0.2
12.3.4	Шимт хөрсний овоолгын чанарын шинжилгээ			0.1
12.3.5	Тусгай зөвшөөрлийн талбайд ургамлын мониторинг хийх			0.3
13. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө				5
13.1	ЭТТ ХК БОМ болон Гэрээтийн БОМ сургалт, зааварчилгаа хүргэх	Жилийн турш	Байгаль орчны мэргэжилтнүүдийг чадавхжуулалт 3-аас доошгүй сургалтанд хамрагдсан байна.	0.2
13.2	Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг зохион байгуулах.	Жилийн турш	БХТ батлах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналтыг сайжруулах, зөрчил дутагдлыг арилгуулсан байна.	1
13.3	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр сумын төвийн зорилтот 30 айл өрхөд эко жорлон байрлуулах /хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан/	Дулааны улиралд	Нийт 30 өрхөд Эко жорлон байрлуулсан байна.	1
13.4	Сумын төвийн 2-с доошгүй худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хашаажуулах	3-р улиралд	Цогтцэций сумын төлөөлөлийн саналын дагуу худгийг сонгож, эрүүл бүсийн хашаа хийнэ.	0.6
13.5	Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр малчдыг туршлага судлуулах	2,3-р улиралд	6 малчинг туршлага судлуулна.	1
13.6	Цагаан-Овоо багийн малчдын хоршооллыг дэмжиж ажиллах	2-р улиралд	Санамж бичиг байгуулсан байна.	1
13.7	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах	Тухайн өдрүүдэд	Дэлхийн зэрлэг амьтан, ургамал хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх өдөр, Дэлхийн усны өдөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр	0.2
14. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө				5
14.1	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон 2024 оны Байгаль орчны менежементийн төлөвлөгөөг	II улиралд	Компанийн сайтад байршуулсан байна.	2.5

	байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах			
14.2	Цогтцэций сумын Цагаан- Овоо, Билгэх, Сийрст, Өгөөмөр багийн иргэд	Жилд 2 удаа	БОМТ болон БОМТ-ний биелэлтийг танилцуулсан байна.	2.5
НИЙТ				100